



emart

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН 2024

СКАЙ ХАЙПЕРМАРКЕТ ХХК

Тайлангийн тухай



Тайлангийн зорилго

“Скай Хайпермаркет” ХХК нь тогтвортой хөгжлийн үнэт зүйлсийг дэмжих үүргийнхээ хүрээнд, Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын гүйцэтгэлээ ил тод тайлагнах зорилгоор хоёр дахь жилдээ энэхүү тогтвортой байдлын тайлангаа олон нийтэд хүргэж байна. Энэхүү тайланд 2024 онд хэрэгжүүлсэн байгаль орчин, нийгмийн хөгжил болон оролцогч талуудтай хийсэн хамтын ажиллагааны бодлого, үйл ажиллагаа, үр дүнг тусгасан бөгөөд бидний тогтвортой хөгжлийн стратегийн зорилго, хэрэгжилтийн уялдаа холбоог илүү ойлгомжтой, нээлттэй болгохыг зорьсон болно. Бид энэхүү тайлангаар дамжуулан хариуцлагатай бизнесийн зарчмыг нийгэм, байгаль орчин, эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийн хүрээнд хэрхэн хэрэгжүүлж буйгаа тайлагнаж, оролцогч талуудтайгаа харилцан итгэлцэл, сайн засаглалд суурилсан түншлэлийг гүнзгийрүүлэн хөгжүүлэхийг зорьж байна.



Тайлагнах зарчим

Энэхүү тайланг боловсруулахдаа “Тайлагналын Олон Улсын Санаачилга” (GRI)-ын суурь зарчим болон холбогдох стандартуудыг баримталсан болно. Мөн “Ризилиенс Консалтинг Сервиз” компанийн гүйцэтгэсэн “2024-Байгаль орчин, Нийгэм, Засаглалын суурь үнэлгээний тайлан”-ийн үр дүнг ашигласан бөгөөд БНСУ-ын “Имарт” компанийн тогтвортой байдлын тайланг загвар, арга зүйн жишээ болгон ашигласан болно.



Тайлант хугацаа

Тайлангийн мэдээлэл нь 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх нэг жилийн хугацаанд хамаарна.



Тайлангийн хамрах хүрээ

Тайланд тусгагдсан мэдээлэл нь Скай Хайпермаркет ХХК-ийн үндсэн бизнесийн үйл ажиллагаа болох Имарт Чингис, Имарт Хороолол, Имарт Хан-Уул, Имарт Баянгол, Имарт Драгон салбар дэлгүүрүүд, Түгээлтийн төв, Гидропоник хүлэмжийн төсөл, Хүнс хөгжүүлэлт, судалгааны төвийг хамарна.

Агуулга

Бидний тухай		Нийгэм	
Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	5	Нийгмийн хариуцлага ба хамтын үнэ цэн	23
Компанийн танилцуулга	6	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал	24
Алсын хараа, үнэт зүйлс	7	Ажилтан төвтэй бодлого	25
Үйл ажиллагааны танилцуулга	8	Олон талт, тэгш боломж	26
Түүхэн тойм	9	Сургалт ба ажилтны хөгжлийн хөтөлбөр	27
Тогтвортой байдлын танилцуулга		Ханган нийлүүлэлтийн тогтвортой байдал, хамтын үнэ цэн	28
Тогтвортой байдлын стратеги	11	Чанар ба хүнсний аюулгүй байдал	29
Материаллаг байдлын үнэлгээ	12	Нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөлөл	30
Оролцогч талуудын харилцаа	13	Засаглал	
2024 оны БОНЗ-ын онцлох ажлууд	14	Төлөөлөн удирдах зөвлөл	32
Байгаль орчин		Гүйцэтгэх удирдлага	33
Байгаль орчны менежментийн тогтолцоо	16	Хариуцлагатай манлайлал	34
Эрчим хүчний хэмнэлт, ногоон технологи	17	Тогтвортой байдлын гүйцэтгэл	
Хог хаягдлын зохистой менежмент	18	ТХЗ-той уялдах нь	36
Нөөцийн зохистой ашиглалт	19	Хавсралт	
Ирээдүйд байгалиа үлдээе!, Ирээдүйн ой	20	Зурган тайлан	39
Ногоон тээвэр, Цаасгүй оффис	21	Шагнал, Хамтрагч байгууллагууд	43

Бидний тухай

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

5

Компанийн танилцуулга

6

Алсын хараа, үнэт зүйл

7

Үйл ажиллагааны танилцуулга

8

Түүхэн тойм

9



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Эрхэм харилцагчид, үйлчлүүлэгчид, хэрэглэгчид, ажилтнууд болон хамтран зүтгэгчид ээ,

“Скай Хайпермаркет” ХХК-ийн 2024 оны Тогтвортой байдлын тайланг хоёр дахь жилдээ ил тод, нээлттэйгээр танилцуулж байгаадаа туйлын баяртай байна.

2024 он бидний хувьд тогтвортой хөгжлийг байгууллагын үндсэн зорилт болгон төлөвшүүлж эхэлсэн, хариуцлагатай өсөлт, эерэг өөрчлөлтөөр дүүрэн онцгой жил байлаа. “Эерэг Имарт” уриан дор бид байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ) зарчмуудыг үйл ажиллагааныхаа салшгүй хэсэг болгож, инновац, дижитал шинэчлэл, хүн төвтэй бодлого, хамтын үнэ цэнийг дэмжсэн олон санаачлагыг амжилттай хэрэгжүүллээ. Тухайлбал, ISO 14001:2015 (Байгаль орчны менежмент), ISO 45001:2018 (Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал) стандартуудыг нэвтрүүлж, байгууллагын бүхий л түвшинд байгаль орчны хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажилтны сайн сайхан байдлыг хангах чиглэлд цогц сайжруулалтыг хэрэгжүүлэн, дотоод чадавхаа бэхжүүлж, оролцогч талуудтай илүү үр дүнтэй хамтран ажиллах үндэс суурь тавигдлаа. Эдгээр алхмууд нь байгууллагын хөгжилд чухал хувь нэмэр оруулаад зогсохгүй, Монгол хүн бүрийн сайн сайхан амьдрал, тогтвортой ирээдүйн төлөөх манай байгууллагын тууштай зорилго юм. “Монгол хүн Та 100 наслаг...” уриа маань бидний үнэт зүйлсийг илэрхийлэхийн зэрэгцээ, нийгмийн өмнө хүлээсэн үүрэгтээ хариуцлагатайгаар хандах уриалга юм.

Бид цаашид ч байгаль орчноо хамгаалах, нөөцөө үр ашигтай зарцуулах, ажилтнуудынхаа сайн сайхан байдлыг хангах, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ бодитоор хэрэгжүүлэх замаар жижиглэн худалдааны салбар дахь тогтвортой хөгжлийн манлайлагч байхын төлөө тууштай ажиллах болно.

Монгол хүний эрүүл, эерэг ирээдүйг оролцогч талуудтайгаа хамтдаа бүтээнэ гэдэгт гүнээ итгэлтэй байна. Та бүхний итгэл, дэмжлэгт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Хамтдаа — Монгол хүн бүрийг 100 наслах ирээдүйн төлөө!

Хүндэтгэсэн,
Л. Жавзмаа
Гүйцэтгэх захирал

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Компанийн нэр	СКАЙ ХАЙПЕРМАКЕТ ХХК
Хаяг	Имарт Чингис салбар, 6 давхар, Токиогийн гудамж-23, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар-13381, Монгол улс
Хуулийн этгээдийн хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Үүсгэн байгуулагдсан огноо	2014 оны 3 дугаар сарын 7-ны өдөр
Гүйцэтгэх захирал	Л.Жавзмаа
Үйл ажиллагааны чиглэл	Худалдаа, үйлчилгээ
Нийт ажилтны тоо	1400+
Цахим хуудас	www.e-mart.mn
Тайлангийн хамрах хугацаа	2024.01.01~2024.12.31

“Скай Хайпермаркет” ХХК нь 2014 онд Монголын үндэсний ууган үйлдвэрлэл, үйлчилгээний компаниудын нэг болох “Алтай Холдинг” группийн охин компани “Скай Трейдинг” ХХК (90%) болон БНСУ-ын “Имарт” компани (10%)–ийн хамтарсан хөрөнгө оруулалтаар байгуулагдсан. Энэхүү хамтын ажиллагаа нь “Оюуны өмч ашиглах эрх олгох, сургалт болон техникийн туслалцаа үзүүлэх тухай гэрээ” (License, Training and Technical Support Agreement)-ний дагуу хэрэгжиж, “Emart” брэндийн албан ёсны франчайз эрхтэйгээр Монгол Улсад үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

2016 онд Имарт Чингис нэртэй анхны салбараа амжилттай нээж, олон улсын худалдааны стандарт, дэвшилтэт үйлчилгээний шинэ соёлыг Монголын зах зээлд амжилттай нутагшуулсан. Өнөөдөр “Скай Хайпермаркет” ХХК нь Улаанбаатар хотод 5 салбар дэлгүүр, Нэгдсэн түгээлтийн төв, Гидропоник хүлэмж, Хүнс хөгжүүлэлт, судалгааны төв, онлайн болон байгууллагын

борлуулалтын платформоор дамжуулан 1,400 гаруй ажилтны хамтаар өдөр бүр 20,000 гаруй үйлчлүүлэгч, хэрэглэгчдэд хүрч үйлчилж байна.


Компанийн толгой компани болох “Алтай Холдинг” ХХК нь Монгол Улсад худалдаа, харилцаа холбоо, үйлдвэрлэл, зочид буудал, мэдээллийн технологи, боловсрол, хэвлэл мэдээллийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг үндэсний хэмжээний тэргүүлэгч компани юм. 1991 онд “Алтай Трейдинг” нэртэйгээр үүсгэн байгуулагдсан тус компани нь өнөөдөр:

- “Чингисхаан цогцолбор” ХХК;
- “Алтай кашмир” ХХК;
- “Скайтел” ХХК;
- “Скай Трэйдинг” ХХК;
- “Юнайтед Бродкастинг Корпорэйшн” (Star HD TV);
- “Дата Кейр” ХХК зэрэг охин компаниудаараа дамжуулан эдийн засаг, бизнесийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж байна.

Харин хамтран хөрөнгө оруулагч болох БНСУ-ын “Имарт” компани нь 1993 онд Сөүл хотод анхны сүлжээ дэлгүүрээ нээж, тус улсын анхны бөгөөд хямд үнийн хайпермаркетын тогтолцоог амжилттай хөгжүүлсэн. Өнөөдөр “Имарт” компани нь БНСУ-д 132 “Emart” хайпермаркет, 22 Traders бөөний төв, 252 “No Brand”, 242 “Emart everyday” дэлгүүрийн үйл ажиллагаа явуулж байна. Мөн АНУ-ын зах зээлд “Bristol Farms”, “Lazy Acres”, “Metropolitan Market”, “New Seasons Market”, “New Leaf” зэрэг таван хүнсний брэндийн хүрээнд 55 дэлгүүр, Азийн бүс нутагт Вьетнамд 3 салбар, Монголд 5 салбар бүхий “Emart” дэлгүүр, Лаосд 1, Филиппинд 16 “No Brand” дэлгүүрийг амжилттай ажиллуулж байна.

Бид “Монгол хүн Та 100 наслаг...” уриан дор өргөн сонголт, хүртээмжтэй үнэ, чанартай үйлчилгээ, байгальд ээлтэй хандлагыг дижитал шийдэлтэй уялдуулан, Монголын жижиглэн худалдааны салбарт тогтвортой хөгжил, хэрэглэгч төвтэй шинэ соёлыг түгээн ажиллах болно.

АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛ



КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

ИМАРТ ЧИНГИС

2016.07

Монгол дахь хамгийн анхны Имарт хайпермаркетийн сүлжээ дэлгүүр Имарт Чингис салбар нээгдэв.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг-13381, 3-р хороо, Токиогийн гудамж-23

ИМАРТ ХАН-УУЛ

2019.09

Имарт Хан-Уул буюу 3 дахь салбараа нээв.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг-17011, 15-р хороо, Их Монгол гудамж-71

EMARTMALL.MN

2020.01

Имарт Online Shopping Mall үйл ажиллагаагаа эхлэв.

ГИДРОПНИК ТӨСӨЛ

2022.10

Хөрс ашиглахгүйгээр ургамлыг шим тэжээлээр баялаг усан уусмалд ургуулах дэвшилтэт технологи бүхий гидропоник төслийн навчид ногоог борлуулалж эхлэв.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг-17070, 3-р хороо, Ноолуурын-43

ИМАРТ БИЗНЕС КЛУБ

Жижиглэнгийн худалдаанаас гадна аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулсан үйл ажиллагааг 2018 оноос явуулж ирсэн бөгөөд 2024 онд Имартын Бизнес Клуб болон тэллээ.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг-17070, 3-р хороо, Ноолуурын -43 businessclub.e-mart.mn



ИМАРТ ХОРООЛОЛ

2017.09

Имарт Хороолол буюу 2 дахь салбараа нээв.

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг-16091, 13-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө.

ТҮГЭЭЛТИЙН ТӨВ

2020.09

Имарт Түгээлтийн төвийг ашиглалтад оруулав.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг-17070, 3-р хороо, Ноолуурын -43

ИМАРТ БАЯНГОЛ

2023.09

Имарт Баянгол буюу 4 дэх салбараа нээв.

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг-16080, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө

ХҮНС ХӨГЖҮҮЛЭЛТ, СУДАЛГААНЫ ТӨВ

2023.12

Гидропоник хүлэмжийн тариалалттай хослуулан "Хүнс хөгжүүлэлт, судалгааны төв"-ийг байгуулж, 2024 оноос албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлэв.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Ноолуурын гудамж-43, 17070.


ИМАРТ ДРАГОН

2024.12

Имарт Драгон буюу 5 дахь салбараа нээв.

Хаяг: Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 29-р хороо, Москва хороолол -18072 Энхтайваны өргөн чөлөө

ТҮҮХЭН ТОЙМ



Тогтвортой байдлын танилцуулга

Тогтвортой байдлын стратеги

11

Материаллаг байдлын үнэлгээ

12

Оролцогч талуудтай харилцах суваг

13

2024 оны БОНЗ-ын онцлох ажлууд

14



ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН СТРАТЕГИ

2023 онд “Тогтвортой Имарт” уриан дор бид анх удаа тогтвортой хөгжлийн үндсэн чиглэлүүдийг (E – Байгаль орчин, S – Нийгэм, G – Засаглал) тодорхойлон, байгууллагынхаа бүх түвшинд тогтвортой байдлын суурь ойлголтыг нэвтрүүлж эхэлсэн. Энэ хүрээнд бид:


- Байгаль орчны чиглэлээр: Монгол Улсын 2030 он хүртэлх хүлэмжийн хийг 22.7 хувиар бууруулах үндэсний зорилтод хувь нэмэр оруулах,
- Нийгмийн чиглэлээр: Оролцогч талуудтайгаа хамтран хөгжиж, нийгмийн хамтын үнэ цэнийг нэмэгдүүлэх,
- Засаглалын чиглэлээр: Сайн засаглал, ёс зүйт менежментийн тогтолцоогоор худалдааны салбарыг тэргүүлэх зорилго болгон ажиллаж эхэлсэн.

Энэ нь манай компанийн хувьд тогтвортой хөгжлийн суурийг тавьсан бөгөөд цаашдын зорилго, үнэт зүйлсээ илүү тодорхой болгосон стратегийн эхлэл юм.

2024 онд бид “Эерэг Имарт” уриан доор өмнөх онд тавьсан суурийг улам гүнзгийрүүлэн, эхлүүлсэн ажлуудаа илүү мэдрэмжтэй, хүн төвтэй байдлаар хөгжүүлэн хэрэгжүүллээ. Тухайлбал:


- Байгальд ээлтэй хэрэглээг дэмжих,
- Ажилтны сэтгэлзүй, сайн сайхан байдлыг эрхэмлэх,
- Үйлчлүүлэгч, хэрэглэгчидтэй ойр, сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн үйлчилгээ үзүүлэх зэргээр тогтвортой байдлыг өдөр тутмын үйл ажиллагааныхаа салшгүй хэсэг болгон төлөвшүүлж байна.

Бидний хувьд тогтвортой хөгжил гэдэг нь зөвхөн бодлого, тогтолцоо бус, харин хүн бүрийн идэвхтэй оролцоо, эерэг хандлага, бодит үйлдлээр илэрдэг амьд үнэт зүйл гэдэгт итгэдэг.



МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

“Ризиалиенс Консалтинг Сервиз” ХХК-ний зүгээс БОНЗ-ын нөлөөллийн хүрээнд авч үзсэн 14 үндсэн хүчин зүйлсийн хүрээнд “Скай Хайпермаркет” ХХК-ийн дэвшүүлсэн зорилтуудыг үнэлж, материаллаг байдлын үнэлгээний матриксыг боловсруулсан байдал:



	Хүчин зүйлс	БОНЗ хүрээ	Товчлол	Материаллаг байдал
1	Хөдөлмөрийн харилцаа	Нийгэм	(LR)	Double / Impact + Financial/
2	Хүнсний аюулгүй байдал	Нийгэм	(FS)	Double / Impact + Financial/
3	Хүний эрх	Нийгэм	(HR)	Impact
4	Тогтвортой худалдан авалт	Нийгэм	(SP)	Impact
5	Нийгмийн хариуцлага	Нийгэм	(CSR)	Impact
6	Хог хаягдал	Байгаль орчин	(WD)	Impact
7	ХАБЭА	Нийгэм	(OHS)	Double / Impact + Financial/
8	Усны хэрэглээ	Байгаль орчин	(H2O)	Impact
9	Эрчим хүчний хэрэглээ	Байгаль орчин	(PC)	Financial
10	Мэдээллийн ил тод байдал	Засаглал	(IT)	Financial
11	Ялгаатай байдал, оролцоо	Засаглал	(DEI)	Impact
12	Ёс зүй	Засаглал	(BE)	Impact
13	Бизнесийн тасралтгүй байдал	Засаглал	(BC)	Financial
14	Хүлэмжийн хийн ялгарал	Байгаль орчин	(CO)	Impact

*Тайлбар

Хос/double материаллаг байдал: Асуудал нь компанийн үйл ажиллагаанд болон оролцогч талуудын хувьд зэрэг өндөр ач холбогдолтой.

Нөлөөллийн материаллаг байдал: Асуудал нь оролцогч талуудын хүлээлт, сонирхолд өндөр ач холбогдолтой.

Санхүүгийн материаллаг байдал: Асуудал нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд өндөр ач холбогдолтой.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ СУВАГ

“Скай Хайпермаркет” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ оролцогч талуудын оролцоог бодитоор хангаж, харилцан итгэлцэлд суурилсан тогтвортой хамтын харилцааг бий болгохыг эрхэм зорилгоо болгон ажилладаг. Бид хэрэглэгчид, ажилтнууд, орон нутгийн

иргэд, төрийн байгууллагууд болон стратегийн түншүүдтэй үйл ажиллагааныхаа бүх түвшинд нээлттэй, ил тод, тогтвортой харилцахыг эрмэлздэг. Тэдний хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн үр дүнтэй сувгаар мэдээлэл солилцож, хамтын үнэ цэнийг бүтээх нь бидний үндсэн зарчмуудын нэг юм.

Үйлчлүүлэгч	Ажилтан	Нийлүүлэгч	Олон нийт	Төрийн байгууллагууд	Санхүүгийн байгууллагууд	Хувьцаа эзэмшигч Хөрөнгө оруулагч	БНСУ-ын Имарт компани	Түнш байгууллагууд ТББ, холбоо
ХАМРАХ ГОЛ АСУУДАЛ								
Тогтвортой бүтээгдэхүүн, үнэ цэн, сэтгэл ханамж, эерэг үйлчилгээний мэдрэмж	Цалин, бүтээмж, сайн сайхан байдал, ажлын орчин, карьер өсөлт	Түншлэл, шударга худалдан авалт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт	Оролцооны төсөл, байгаль орчны санаачилга, хамтын үнэ цэн	Хууль тогтоомжийн нийцлийн хяналт, нээлттэй тайлагнал	Санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн өсөлт	Стратегийн хяналт, хөрөнгө оруулалт, тогтвортой байдал	Франчайз хяналт, стратеги	Хамтран хэрэгжүүлэх төсөл, оролцооны санаачилга, олон талт хамтын ажиллагаа
ХАРИЛЦАХ СУВАГ								
Хэрэглэгчийн үйлчилгээний төв, Үйлчлүүлэгч, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, Имарт апп, веб, албан ёсны нийгмийн сүлжээ (Facebook, YouTube, Instagram, TikTok), цахим шуудан, санал хүсэлтийн хайрцаг, цахилгаан холбоо	Дотоод мэдээллийн сувгууд, бүх нийтийн хурал, ажилтны сэтгэл ханамжийн судалгаа, цахим санал, асуулга, ажилтны дуу хоолой, олон нийтийн үйл ажиллагаа, сургалт хэлэлцүүлэг	B2B уулзалт, гэрээ, хамтарсан шийдэл, Имарт апп, платформ (Urtu.mn, business-club.e-mart.mn), судалгаа, хамтын ажиллагааны уулзалт	Имарт апп, веб, албан ёсны нийгмийн сүлжээ (Facebook, YouTube, Instagram, TikTok), Хэрэглэгчийн үйлчилгээний төв, цахим шуудан цахилгаан холбоо	Олон нийтийн уулзалт, санал асуулга, сургалт, төсөл мэлээллийн хөтөлбөрүүд, хэлэлцүүлэг, албан бичиг, цахим шуудан, аудит, тайлан, хяналт	Албан бичиг, аудит, уулзалт, цахим шуудан, цахилгаан холбоо	ТУЗ, хөрөнгө оруулагчдын хурал	ТУЗ-ийн хурал цахим хурал, тайлан, Франчайз сургалт, шууд харилцаа	Меморандум, сургалт, төсөл, нөлөөллийн судалгаа, орон нутгийн хэлэлцүүлэг
МОНИТОРИНГ АРГАЧЛАЛ								
NPS оноо, сэтгэл ханамжийн судалгаа, үйлчлүүлэгч, хэрэглэгчийн санал асуулгын тайлан	Ажилтны сэтгэл ханамжийн судалгаа, 360° үнэлгээ, сар бүрийн гүйцэтгэлийн үнэлгээ	Нийлүүлэгчийн үнэлгээний систем, гэрээний гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ	Оршин суугчдын санал асуулга, төсөл бүрийн нөлөөллийн тайлан	Хяналт, аудитын дүгнэлт, тайлангийн батламж, хуулийн нийцэл	Зээлийн эрсдлийн үнэлгээ, БОНЗ-н мэдээлэлд суурилсан дотоод үнэлгээ, санхүүгийн хяналт, тайлагнал	ТУЗ-ийн шийдвэр хэрэгжилтийн хяналт	Франчайз стандартын үнэлгээ	Төсөл хэрэгжилтийн үр дүнгийн дүгнэлт, хамтрагч байгууллагын үнэлгээ

2024 ОНЫ БОНЗ-ЫН ОНЦЛОХ АЖЛУУД

БАЙГАЛЬ ОРЧИН

ISO 14001:2015 стандартын нэвтрүүлэлт:

Байгаль орчны менежментийн тогтолцоог салбар дэлгүүр, агуулахын түвшинд нэвтрүүлж, хог хаягдлын менежмент, эрчим хүч, усны хэрэглээний хяналтыг сайжруулах нөхцлийг бүрдүүлсэн.

Эрчим хүчний хэмнэлт:

Сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүч хэмнэх хөргүүр, барилгын шийдэл нэвтрүүлэх зэргээр нөөцийн хэрэглээг илүү зохистой болгоход чиглэсэн арга хэмжээ авч ажилласан.

Гидропоник хүлэмж ба тогтвортой хүнсний үйлдвэрлэл:

Дотоод орчны гидропоник тариалалтын аргаар салатны навч ургуулах туршилт хийж, хөрс болон усны хэрэглээний нөлөөллийг бууруулах чиглэлд ахиц гаргасан.

Хүнсний хаягдлыг дахин ашиглах:

Хаягдал хүнсийг бордоо болгон хувиргах туршилтыг хэрэгжүүлж, нийт 800кг хүнсний хаягдлыг дахин ашигласнаар хаягдлын хэмжээг тодорхой хэмжээнд бууруулсан.

“Ирээдүйн ой”- “Forest Tomorrow” төсөл:

Байгаль орчны нөхөн сэргээлт, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг оролцоог нэмэгдүүлэх зорилгоор БНСУ-ын “Имарт” компанийн хөрөнгө оруулалттай “Ирээдүйн ой” (Forest Tomorrow) мод тарих 5 жилийн төслийг амжилттай эхлүүлээ.

НИЙГЭМ

ISO 45001:2018 стандарт нэвтрүүлэлт:

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын тогтолцоог байгууллагын хэмжээнд нэвтрүүлж, ажлын орчны эрсдэлийг бууруулах, ажилтны эрүүл, аюулгүй нөхцөлийг хангах суурийг бүрдүүлсэн.

Ажилтны сайн сайхныг дэмжих хөтөлбөрүүд:

“Цалинтай ээж”, “Ажилтны сувилал”, “Хүүхдийн өрөө” зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, ажилтнуудын амьдралын нөхцөл, ажлын сэтгэл ханамжийг сайжруулахад чиглэсэн.

Имарт Академи, дотоод сургагч багш:

Ажилтны ур чадвар, карьерын өсөлтийг дэмжсэн сургалтын тогтолцоо бий болсон.

“Ажилтай ахмад”, “Орлоготой оюутан” хөтөлбөр:

Ахмад настай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, оюутан залуусыг орлоготой, ажлын туршлагатай болгох зорилготойгоор хэрэгжүүлж, тэгш оролцоог дэмжсэн.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих бодлого:

Түрээслэгчдийн дийлэнх нь эмэгтэй бизнес эрхлэгчид байгаа тул тэдэнд зориулсан маркетинг, зөвлөгөө, сургалтын дэмжлэгийг тогтмол үзүүлж байна.

Имарт Бизнес Клуб:

2018 оноос хойш байгууллагын харилцагчдад зориулсан B2B үйлчилгээг Имарт Бизнес Клуб болгон хөгжүүлж, HORECA, уул уурхай, катеринг, хүнсний үйлдвэрлэлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Гүем болон нийгмийн хариуцлагын аянууд:

Хүүхэд, залуучуудад байгаль орчин, нийгмийн үнэ цэнийг таниулах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор олон нийтийн аянууд зохион байгуулсан.

ЗАСАГЛАЛ

Жендэрийн тэгш оролцоо:

2024 онд Төлөөлөн удирдах зөвлөлд анх удаа эмэгтэй гишүүн томилогдож, эмэгтэй төлөөлөл 25%/75% харьцаатай боллоо. Мөн эмэгтэй эзэмшигчтэй ханган нийлүүлэгчийн мэдээллийн санг бүрдүүлж эхэлсэн.

Дижитал шилжилт:

Microsoft 365, ERP системүүдийг нэвтрүүлж, хүний нөөц, санхүү, баримт бичгийн хяналт, мэдээллийн аюулгүй байдал, шийдвэр гаргалтын ил тод байдлыг сайжруулсан.

Шинэ харилцаа, хамтын ажиллагаа:

Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо болон “Women-Owned” санаачлагад элсэж, тэгш боломжийг дэмжсэн бизнесийн үнэт зүйлд суурилсан хамтын ажиллагааг өргөжүүлсэн.

Ил тод тайлагнал:

Анхны тогтвортой байдлын тайлангаа олон нийтэд нээлттэй танилцуулсан.

Байгаль орчин, нийгэм, засаглалын суурь үнэлгээ:

Байгууллагын 2024 оны Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын гүйцэтгэлийг үнэлэх суурь үнэлгээг хийлгэлээ. Энэхүү үнэлгээ нь олон улсын GRI, ISO, НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтууд болон үндэсний бодлогуудтай нийцүүлсэн шалгуураар үнэлсэн бөгөөд компанийн эрсдэл, боломжуудыг тодорхойлж, БОНЗ стратеги төлөвлөлт, тайлагналын суурийг бүрдүүлэв.

Байгаль орчин



Байгаль орчны менежментийн тогтолцоо 16


Эрчим хүчний хэмнэлт ба ногоон технологи 17

Хог хаягдлын зохистой менежмент 18

Нөөцийн зохистой менежмент 19

Ирээдүйд байгалиа үлдээе!, Ирээдүйн ой 20

Ногоон тээвэр, Цаасгүй оффис 21



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

“Скай Хайпермаркет” ХХК нь Монгол Улсын “Алсын хараа-2050”, “Ногоон хөгжлийн бодлого”, болон НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго”-уудтай уялдуулан, байгаль орчны менежментийн тогтолцоог бизнесийн үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллаж байна.

2024 онд олон улсын ISO 14001:2015 (Байгаль орчны менежментийн тогтолцоо) стандартыг нэвтрүүлж, байгууллагын түвшинд байгаль орчны эрсдэл, нөлөөллийг тогтоох, хянах, бууруулах үйл явцыг системтэй болгоход анхаарч ажиллалаа.

“Эерэг Имарт” уриан дор 2024 оны байгаль орчны үйл ажиллагааны хүрээнд дараах чиглэлүүдээр ажиллав:

- Эрчим хүчний хэрэглээг бууруулах, сэргээгдэх эх үүсвэрийг дэмжих, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор эрчим хүч хэмнэх тоног төхөөрөмж, барилгын шийдлүүдийг нэвтрүүлсэн.
- Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, дахин ашиглах, хог ачилтын үр ашгийг сайжруулах чиглэлээр менежментийн үйл ажиллагааг сайжруулсан.
- Үйлчлүүлэгч, хэрэглэгчдэд байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүний сонголтыг өргөжүүлж, тогтвортой хэрэглээг дэмжих зорилготой мэдээлэл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Цаашид байгаль орчны менежментийн тогтолцоог байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтвортой төлөвшүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эерэг өөрчлөлт бий болгох чиглэлд тасралтгүй сайжруулалт хийхээр зорин ажиллаж байна



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ БА НОГООН ТЕХНОЛОГИ

Имарт Баянгол салбарын дээврийн заагдсан хэсэгт 35 кВт хүчин чадалтай онгрид төрлийн нарны эрчим хүчний системийг анх удаа туршилтаар суурилуулж, судалгаа болон туршилтын үр дүнд үндэслэн тогтмол хэрэглээнд амжилттай нэвтрүүллээ. Энэхүү систем нь хоёр талдаа нарны элементтэй 660Вт чадал бүхий хавтанг ашигладаг бөгөөд ижил төрлийн нэг талт хавтантай харьцуулахад 10–20%-иар илүү эрчим хүч үйлдвэрлэх боломжтой. Ингэснээр бага талбайд илүү өндөр үр ашигтай систем байршуулах боломжийг бүрдүүлсэн.Тус онгрид систем нь худалдааны төвийн зарим гэрэлтүүлэг болон тоног төхөөрөмжийн цахилгааны хэрэглээг хангаж байгаа бөгөөд илүүдэл эрчим хүчийг төвийн эрчим хүчний сүлжээнд нийлүүлж байна.

Уг төрлийн системийг суурилуулсан анхны хэрэглээний амжилттай жишээ болж байгаа юм.

Гол үр дүн ба цаашдын боломж:

- Системийн үйл ажиллагааг ухаалаг гар утаснаас хянах боломжтой бөгөөд гаргасан эрчим хүч болон бусад үзүүлэлтийг бодит хугацаанд хянаж, тооцоолох нөхцөлийг бүрдүүлсэн.
- Системийн ажиллагааны талаарх өгөгдөл, хэмжилт нь эрчим хүчний салбарын судлаачид, мэргэжлийн байгууллагуудад нээлттэй байж, цаашид ижил төрлийн шийдлийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлж байна.
- Батарейгүй, шууд хэрэглээнд зориулсан нарны

эрчим хүчний системийн боломжит хувилбар болохыг туршилтаар баталгаажуулсан.

- Энэхүү суурилуулалт нь 35 кВт хүчин чадалтай онгрид төрлийн системийг үйлдвэрлэл, хэрэглээнд нэгтгэсэн анхны тохиолдол бөгөөд системийн технологи, ашиглалтын заавар, хяналтын шийдлийг боловсруулж компанийн дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

Энэ нь цаашид батарейгүй, өндөр үр ашигтай нарны системийг бусад салбаруудад өргөжүүлэн хэрэгжүүлэх суурь болж байна.

ҮР ДҮН (2024 ОН):

21,314.7 кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэсэн

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛСЭН ЭЭРЭГ НӨЛӨӨ:

21,274.8 кг CO₂ (нүүрстөрөгчийн давхар исэл) ялгарлыг бууруулсан

1,174 мод тайрахаас сэргийлсэнтэй дүйцэхүйц үр нөлөө

8,535.5 кг нүүрс шатаахаас татгалзсантай тэнцэх хэмнэлт



Он	Улс	Хамрах хүрээ	Эх үүсвэр	Бодит мэдээлэл	Нэгж
2024	Монгол	Имарт 5 салбар дэлгүүр, түгээлтийн төв	Цахилгаан	20 498 288,41	кВт.цаг
			Дулаан	41 925,83	ГЖ
			Газ	103 088,56	кг
			Дизель	16 089,59	л
			Дизель / автомашин/	7 817,00	л

Байршлын нэр	2024 оны Хүлэмжийн хийн ялгаруулалт /тонн CO ₂ eq/		
	Шууд ялгаруулалт (Scope 1)	Шууд ялгаруулалт (Scope 1)	Нийт
Имарт 5 салбар дэлгүүр, Түгээлтийн төв	392.431	27,028.616	27,421
НИЙТ	392.431	27,028.616	27,421

* “Korea Foundation for Quality ” агентлагийн “Хүлэмжийн хийн ялгаруулалтын баталгаажуулах тайлан”

ХОГ ХАЯГДЛЫН ЗОХИСТОЙ МЕНЕЖМЕНТ

“Скай Хайпермаркет” ХХК нь хог хаягдлыг байгаль орчинд сөрөг нөлөө багатайгаар удирдах, тогтолцоот, шат дараалсан менежментийн зарчмыг бүх салбар, нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэрэгжүүлж байна. Хог хаягдлыг ангилах, зайлуулах, дахин ашиглах, халдваргүйжүүлэх зэрэг үйл явцыг тогтмол зохион байгуулж, сайжруулалт хийсээр байна

Алхам	Үйл ажиллагааны тайлбар	Хариуцсан тал
1. Анхан шатанд ангилан ялгах	Хогийг төрөл тус бүрээр (цаас, цаасан хайрцаг, хуванцар, шил, энгийн хог хаягдал гэх мэт) ангилах	Үндсэн ажилтнууд
2. Ангилсан хог хаягдлыг пресслэх	Хогоо хаяхдаа ялгасан цаасан хайрцаг, цэвэр цаас, хуванцар хаягдлыг пресслэнэ.	
3. Хэрэглээний хайрцаг цуглуулах	Ялгасан хог хаягдлаас дахин ашиглах боломжтой цаасан хайрцаг цуглуулах. Нөөц хайрцгийг сав баглаа боодлын хэсэгт хүргэх.	
4. Хог хаягдал зайлуулах	Хог хаягдлыг 2 цаг тутам зайлуулах, зай талбайг чөлөөлөх.	Үйлчилгээний ажилтан
5. Ариутгал, цэвэрлэгээ үйлчилгээ хийх	Хог хаягдлыг цэвэрлэн зай талбайг чөлөөлсний дараа өдөрт 2 удаа тогтмол цагт ариутгал, халдваргүйжүүлэлт хийх.	
6. Хог хаягдлыг тээвэрлэх, хаях	Зай талбайг цэвэрлэж, ариутгал хийсний дараа тээвэрлэлтийн гэрээт компанитай холбогдон, хог хаягдлыг түргэн шуурхай ачуулах.	

Салбар бүрийн байршил, онцлогт тохируулан төрийн болон хувийн хэвшлийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудтай гэрээ байгуулж, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйлчилгээг авч байна.

- Цаас, гялгар уут, хөөсөнцөр зэрэг дахин боловсруулах боломжтой хаягдлыг пресслэн шахаж, гэрээт боловсруулах үйлдвэрт шилжүүлдэг.
- Хэрэглэсэн тос нь дахин боловсруулалтын хүрээнд хоёрдогч ашиглалтад шилжиж, ахуйн хэрэглээний саван болгон хувиргагдаж, компанийн дотоод хэрэгцээнд ашиглагдаж байна.

Хог хаягдлын төрөл	Хэмжих нэгж	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал	тн	2,391
Цаас	кг	188,780
Гялгар уут	кг	5,446
Тос	л	5,396
Модон подоон	ш	3,345
Аюултай хог хаягдал	кг	57

Хүнсний хаягдлыг дахин боловсруулах:
2024 онд компанийн зүгээс байгальд ээлтэй, хог хаягдлыг бууруулах шинэ санаачилгын хүрээнд хүнсний хаягдлыг бордоо болгон дахин боловсруулах туршилтын төслийг анх удаа хоёр салбар дэлгүүрт хэрэгжүүлэв.


- 8 сарын хугацаанд нийт 800 кг хүнсний хаягдлыг 100кг бордоо болгон хувиргасан.

- Энэхүү хэмжээ нь 2024 оны нийт хог хаягдлын ердөө 0.03%-ийг эзэлж байгаа ч цаашид өргөжүүлэн хэрэгжүүлэхэд чухал суурь болсон анхны алхам байлаа.
- Туршилтын үр дүнд үндэслэн хүнсний хаягдлыг дахин боловсруулах хөтөлбөрийг бусад салбаруудад үе шаттайгаар нэвтрүүлэхээр төлөвлөж байна.
- Системтэй, зохион байгуулалттай хэрэгжүүлснээр хүнсний хаягдлыг бууруулах, байгаль орчинд үзүүлэх нөлөөг багасгах, ногоон эдийн засгийн суурийг тавих боломжийг бий болгоно гэдэгт итгэлтэй байна.

Үйл ажиллагааны зарчим:

- 1-р хайрцагт хүнсний хог хаягдал болон сийрэгжүүлэгч нэмэлт материалуудыг дүүрэх хүртэл нь хийнэ.
- 1-р хайрцаг дүүрсэн тохиолдолд 2-р хайрцаг руу шилжүүлнэ.
- Дахин 1-р хайрцгийг дүүргэж хүнсний хог хаягдал болон нэмэлт материал нэмж
- 1-р хайрцаг дахин дүүрэхэд 2-р хайрцгийг 3-р хайрцаг руу, 1-р хайрцгийг 2-р хайрцаг руу тус тус шилжүүлнэ.

3-н хайрцаг тус бүрийн хольцыг долоо хоногт 2~3 удаа сайтар холино. Дээрх үйл ажиллагаа нь хүнсний хог хаягдлын хэмжээнээс хамааран хугацаа нь янз бүр байх боловч дунджаар 3~6 сарын хугацаанд үргэлжилнэ.



НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ

УСНЫ ХЭРЭГЛЭЭНИЙ МЕНЕЖМЕНТ

“Скай Хайпермаркет” ХХК-ийн бүх салбар, объектууд нь Улаанбаатар хотын төвлөрсөн бохир усны сүлжээнд холбогдсон бөгөөд усны чанар болон бохир усны менежментийг улирал тутам мэргэжлийн байгууллагаар шинжлүүлж, үнэлгээ хийлгэж байна. Мөн бүх усны худаг болон бохирын системийг жилд хоёр удаа, хавар болон намрын улиралд гүн цэвэрлэгээнд хамруулдаг. Сүүлийн жилүүдэд салбаруудын тоо нэмэгдэж, үйл ажиллагааны цар хүрээ тэлсэнтэй холбоотойгоор усны хэрэглээ нэмэгдсэн ч, компанийн зүгээс усны үр ашигтай хэрэглээг сайжруулах дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна:

- Мэдрэгчтэй угаалтуур болон суултуур суурилуулснаар усны хэрэглээг ойролцоогоор 50 хувиар бууруулав.
- Гидропоник хүлэмжийн системд шинэчлэл хийж, системийн усыг хагас жилд нэг удаа солих боломжтой болгосон. Гарсан хаягдал усыг гадна талбайн мод услахад ашигласнаар дахин ашиглалтын хувь нэмэгдэж, хотын ногоон байгууламжийг арчлахад хувь нэмэр оруулж байна.

		Жил	Нийт дүн, тн
Усны хэрэглээ	Үзүүлэлт, хэмжих нэгж (тн)	2022	60,237.93
		2023	68,359.83
		2024	87,106.60

ГАЗРЫН НӨӨЦИЙН ЗОХИСТОЙ АШИГЛАЛТ

Компанийн үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр ажиллах орчны багтаамжийн асуудал үүссэнтэй холбоотойгоор “Скай Хайпермаркет” ХХК нь шинэ газар эзэмших бус, байгаа нөөц газраа үр ашигтай ашиглах шийдлийг сонгож, байгальд ээлтэй, хариуцлагатай хандлагыг нэвтрүүлж байна. 2024 онд төв оффисыг Имарт Чингис салбарын барилгын дээд хэсэгт нэмэлт 7 давхар болгон төлөвлөж, 2025 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Энэхүү шийдэл нь дараах ач холбогдолтой:

- Хотын төв хэсэгт шинээр газар ашиглах шаардлагыг багасгах;
- Хөрсний хэт ашиглалт, бохирдлоос сэргийлэх;
- Газрын нөөцийг дахин ашиглан дотоод орчны багтаамжийг нэмэгдүүлэх;
- Барилгын зардлыг оновчтой төлөвлөн зохион байгуулснаар эдийн засгийн болон байгаль орчны үр өгөөжийг хослуулах;

Энэхүү арга хэмжээ нь компанийн нөөцийн менежментэд байгальд ээлтэй, шинэлэг шийдлийг амжилттай хэрэгжүүлж буй жишээ юм.



БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

“Скай Хайпермаркет” ХХК нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ биологийн олон янз байдлыг хамгаалах, байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах зарчмыг тууштай баримталдаг. Тус компани нь тусгай хамгаалалттай газар нутаг, ховор амьтан, ургамал бүхий бүс нутагт ямар нэгэн үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд соёлын өв, байгаль орчныг хүндэтгэх үүргээ бодитой хэрэгжүүлж байна.

Өмнөх жилүүдэд хэрэгжүүлсэн байгаль орчны санаачлагуудыг үргэлжлүүлэн арчилж тордон, хамгаалан ажиллаж байна.

Үүнд: “Бичил цэцэрлэг” – 1,800 м² (үүнээс 1,300м² нь мод, зүлэг), салбар дэлгүүрийн гадна – 525м² ногоон байгууламж, түгээлтийн төвийн гадна – 660м² ногоон байгууламж.

Эдгээр ногоон байгууламжууд нь байгаль орчны тэнцвэрт байдалд эерэгээр нөлөөлөхөөс гадна агаарын чанарыг сайжруулж, хотын дулааны хуримтлалыг бууруулахад хувь нэмэр оруулж, ажилтнууд болон үйлчлүүлэгчдийн тав тухтай орчныг бүрдүүлж байна.



ИРЭЭДҮЙД БАЙГАЛИА ҮЛДЭЭЕ!

“Скай Хайпермаркет” ХХК нь залуу үеийнхэнд байгаль орчны зөв хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 2021 оноос эхлэн жил бүрийн 6 дугаар сарын 1-ний хүүхдийн баярыг тохиолдуулан ажилтнуудын хүүхдүүдэд модны үрсэлгээ бэлэглэх санаачилгыг хэрэгжүүлж байна.

Уг санаачилга нь ажилтнуудын маань гэр бүлийн хүсэн хүлээдэг тогтмол уламжлал болоод байгаа бөгөөд 2024 онд 1,421 ширхэг агч болон голт бор модны үрсэлгээ бэлэглэж, мод тарих ач холбогдлын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгаа өгсөн.

Санаачилгын зорилго нь зөвхөн бэлэг өгөхөд бус, хүүхдүүдэд дараах хандлага, дадлыг төлөвшүүлэхэд оршдог:

- Байгаль дэлхийтэй харилцан хүндэтгэлтэй хандах;
- Өөрийн тарьсан модоо арчилж, ургалтыг нь ажиглах замаар байгаль орчны талаар суралцах;
- Хувь хүний оролцоо байгаль орчинд нөлөөлж чаддаг гэдгийг ойлгох;

Энэхүү үйл ажиллагаа нь хүүхдүүдийн оролцоог идэвхжүүлж, гэр бүл дунд байгаль хамгааллын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, ирээдүйн ногоон иргэн, хариуцлагатай хэрэглэгчийг төлөвшүүлэх зорилготой урт хугацааны хүмүүжлийн хөрөнгө оруулалт юм.



ИРЭЭДҮЙН ОЙ - FOREST TOMORROW

“Скай Хайпермаркет” ХХК нь “Forest Tomorrow” буюу “Ирээдүйн ой” төслийг 2024 онд Монгол Улсад амжилттай эхлүүллээ. Тус төсөл нь байгаль орчны тогтвортой байдлыг хангах, Монгол Улсад ойжуулалтын үйл ажиллагааг дэмжих зорилготой. БНСУ-ын “Имарт” компанийн санаачилга, санхүүжилтээр хэрэгжиж буй тус санаачлагад “Future Forest”, “Азийн ойон хамтын ажиллагааны байгууллага” (AFoCo), БНСУ-ын “Ойон алба” (Korea Forest Service), Монгол-Солонгосын “Ногоон хэрэм” төслийн III шат зэрэг олон улсын байгууллагууд, мөн “Скай Хайпермаркет” ХХК-ийн ажилтнууд сайн дурын үндсэн дээр оролцож байна.

Энэхүү үйл ажиллагаа нь төр, хувийн хэвшил болон олон улсын байгууллагуудын уялдаа холбоо, үр дүнтэй түншлэлийн бодит илэрхийлэл болж байна.

Төслийн хүрээнд 5 жилийн хугацаанд 4.5 га талбайд нийт 15,000 мод тарих зорилт тавьсан бөгөөд энэ нь усны нөөцийг хамгаалах, хөрсний элэгдэл, цөлжилтийг бууруулах, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжих зэрэг олон талын ач холбогдолтой юм.

“Ирээдүйн ой” төсөл нь зөвхөн мод тарихаар хязгаарлагдахгүй, арчилгаа, усалгааг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор тогтмол хийж, цэцэрлэгжүүлэлт, төгөл хэлбэрийн ногоон байгууламжийг бүрдүүлэх, ажилтнуудын оролцоог нэмэгдүүлэх зэргээр ногоон соёлыг төлөвшүүлж буй тогтвортой ойжуулалтын цогц загвар юм.



НОГООН ТЭЭВЭР

“Скай Хайпермаркет” ХХК нь 2020 оноос эхлэн emartmall.mn вэб сайт болон 2022 оноос Emart Mongolia аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэд цахим худалдаа, хүргэлтийн үйлчилгээг тогтмол үзүүлж эхэлсэн. Энэхүү үйл ажиллагаа нь зөвхөн хэрэглэгчийн тав тухыг хангахад чиглээгүй, харин байгаль орчин, нийгэм, эдийн засгийн хувьд илүү хариуцлагатай хэлбэрт шилжих алхмыг давхар эхлүүлсэн юм.

- 2023 оноос эхлэн уламжлалт шатахуунт тээврийн хэрэгслийг цахилгаан тээврийн хэрэгслээр солих ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн.
- 2024 онд хүргэлтийн маршрутыг оновчтой болгох зорилгоор What3Words, Google Maps зэрэг системийг нэвтрүүлснээр шатахууны хэрэглээг 11%-иар бууруулан, ойролцоогоор 38,933 кг хүлэмжийн хий ялгарахаас сэргийлсэн.



Шуурхай захиалга:
Шуурхай хүргэлтийн хүргэгдэх цаг 59 минут.
Хүргэлт бэлтгэгдэж гарах салбар бүрээс 2км доторх хороод шуурхай хүргэлтээр үйлчлүүлэх боломжтой.



Энгийн захиалга:
Улаанбаатар хотын 6-н дүүргийн бүх хороонд хамрагдана. Үйлчлүүлэгчийн захиалга хийх хугацаанаас хамааран хүргүүлэх цагийн сонголт гарч ирнэ. Хүргэлтийн цаг 12:00 ~ 16:00 16:00 ~ 21:00



Хот хоорондын захиалга:
21-н аймаг болон Улаанбаатар хотын алслагдмал 3-н дүүрэгт хүргэлт хийгдэнэ. Хүргэгдэх хугацаа хаягаасаа хамаараад 48-72 цаг





7-9 км	Шуурхай хүргэлт 07 амьрт дотор \$ 0.0001
1-3 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
10-15 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
15-20 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
20-25 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
25-30 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
30-35 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
35-40 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
40-45 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
45-50 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
50-55 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
55-60 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
60-65 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
65-70 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
70-75 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
75-80 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
80-85 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
85-90 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
90-95 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001
95-100 км	Энгийн хүргэлт 3-24 амьрт дотор \$ 0.0001

ЦААСГҮЙ ОФФИС – ЦАХИМ ШИЛЖИЛТ

Байгууллагын дотоод үйл ажиллагаанд цаасны хэрэглээг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх дараах ажлуудыг шат дараалсан байдлаар хэрэгжүүлээ:

- Цаасны хэрэглээ өндөртэй хүний нөөц болон санхүүгийн нэгжид ERP систем нэвтрүүлж, баримт бичиг, маягт, тайлан, зөвшөөрлийн процессыг бүрэн цахимжуулсан.
- Scan-Go киоск ашиглан төлбөрийн баримтыг хэрэглэгчийн цахимаар илгээдэг системийг нэвтрүүлснээр цаасан баримтын хэрэглээг бууруулсан.
- PrinterLogic системийг төв оффист нэвтрүүлж, зөвхөн баталгаажсан эрх бүхий ажилтан хэвлэх эрхтэй болгосон. Ингэснээр давхардсан, шаардлагагүй хэвлэлт буурч, цаасны хэрэглээ мэдэгдэхүйц багассан.
- Хуванцар гишүүнчлэлийн картыг бүрэн халж, хэрэглэгчдийг цахим апп-д суурилсан гишүүнчлэлд бүрэн шилжүүлсэн.



Нийгэм

Нийгмийн хариуцлага ба хамтын үнэ цэн 23

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал 24

Ажилтан төвтэй бодлого 25

Олон талт байдал, тэгш боломж 26

Сургалт ба ажилтны хөгжлийн хөтөлбөр 27

Ханган нийлүүлэлтийн тогтвортой байдал, хамтын үнэ цэн 28

Чанар ба хүнсний аюулгүй байдал 29

Нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөлөл 30



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ХАМТЫН ҮНЭ ЦЭН

“Скай Хайпермаркет” ХХК нь тогтвортой хөгжлийн зорилгоо ажилтан, харилцагч болон оролцогч талуудтай хамтран хамтын үнэ цэнийг бий болгох зарчимд тулгуурлан хэрэгжүүлж, бизнесийн амжилтаа нийгмийн хариуцлагатай уялдуулахыг эрхэмлэн ажиллаж байна.

Бид ажилтан, үйлчлүүлэгч, олон нийт, хамтрагч байгууллагуудын сайн сайхны төлөө бодит хувь нэмэр оруулахыг компанийн үндсэн зорилгын нэг хэмээн тодорхойлсон. 2024 онд “Эерэг Имарт” уриа дор дараах үндсэн чиглэлд суурилсан нийгмийн хариуцлагын бодлого, арга хэмжээг хэрэгжүүлээ.

Ажилтан төвтэй хөтөлбөр:

Компанийн зүгээс тэгш боломжийг хангах, ялгаварлан гадуурхалтаас ангид, олон талт байдлыг хүндэтгэсэн ажиллах орчин бүрдүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

Мөн ажилтнуудын ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх сургалт, нийгмийн хамгааллын тогтолцоог үе шаттайгаар сайжруулах ажлыг хэрэгжүүлж байна.



Түүнчлэн, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал (ХЭМАБ) чиглэлээр олон улсын ISO 45001:2018 стандартын шаардлагад нийцсэн менежментийн тогтолцоог нэвтрүүлж, сургалт, хяналт, хөрөнгө оруулалтыг тогтмол нэмэгдүүлэн ажиллаж байна.

Хамтрагч байгууллагуудтай хамтын үнэ цэнийг бүтээх

Бид ханган нийлүүлэгч болон гэрээт түншүүдтэй харилцан ашигтай, нээлттэй, шударга хамтын ажиллагааг дэмжиж, байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын хариуцлагыг хамтдаа хэрэгжүүлэх анхны алхмуудыг амжилттай эхлүүлээд байна.

Иргэд, олон нийтийн оролцоог дэмжих

Иргэд, оршин суугчид, үйлчлүүлэгчид, хэрэглэгчид, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ил тод, хүртээмжтэй олон талт үйл ажиллагааг зохион байгуулсан ба энэ нь оролцогч талуудын хамтын ажиллагаа, ойлголцлыг бэхжүүлэхэд чухал үүрэгтэй байлаа.

Олимпизм ба эрүүл амьдралын хэв маягийг дэмжих

Эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжих зорилгоор “Монгол хүн Та 100 наслаг...” уриан дор Үндэсний олимпийн хороо болон бусад спортын холбоодтой хамтран ажиллаж, хүүхэд, залуучуудыг хамарсан спортын үйл ажиллагааг дэмжин ажиллалаа.

Эдгээр үйл ажиллагаа, санаачлага, хөтөлбөрүүд нь “Скай Хайпермаркет” ХХК-ийн нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөллийг нэмэгдүүлэхээс гадна ажилтнуудын оролцоог бэхжүүлж, хамтран хөгжих, тогтвортой, шударга харилцаанд суурилсан бизнесийн соёлыг төлөвшүүлэх чухал хөшүүрэг болж байна.



ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

“Скай Хайпермаркет” ХХК нь ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалахыг байгууллагын тогтвортой хөгжил, урт хугацааны амжилтын үндэс суурь гэж үздэг. Иймд бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) үйл ажиллагааг Монгол Улсын хууль, тогтоомж, холбогдох дүрэм журмын хүрээнд жил бүр төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулалтын зарчимд тулгуурлан хэрэгжүүлдэг.

2024 онд бид олон улсын ISO 45001:2018 (хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо) стандартыг амжилттай нэвтрүүлж, байгууллагын хэмжээнд албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн нь энэ чиглэлд гаргасан томоохон ахиц байлаа. Цаашид энэхүү стандартыг байгууллагын соёлын салшгүй нэг хэсэг болгон бүрэн нутагшуулах, тогтолцооны үр ашиг, үр нөлөөг улам нэмэгдүүлэхэд чиглэн ажиллана.

ХАБЭА-н үндсэн үйл ажиллагаа ба хэрэгжилт:

Эрсдэлийн үнэлгээ, хяналт: Байгууллагын бүх түвшинд ХАБЭА-тай холбоотой эрсдэлийг жил бүр тогтмол үнэлж, хяналтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, үр нөлөөг нь тогтмол хянаж байна.

Аюулгүй ажиллагааны зааварчилгаа: Ажлын байр тус бүрт зориулсан аюулгүй ажиллагааны зааварчилгаа боловсруулж, “Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааны дэвтэр”-ээр өдөр тутмын хяналт, гүйцэтгэлийг бүртгэж байна.

Гурван шатны үзлэг: Дотоод хяналтын гурван шатны үзлэгийг тогтмол зохион байгуулж, илэрсэн зөрчил, эрсдэлийг арилгах сайжруулалтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг.

Сургалт, чадавхжуулалт: Анхан шатны тусламж үзүүлэх ажилтнуудад зориулсан сургалт; үйлдвэрлэлийн осол судлан бүртгэх комиссын гишүүдэд чиглэсэн чадавхжуулах сургалт; удирдах түвшний ажилтнуудад ХАБЭА-н мэдлэг нэмэгдүүлэх сургалт; ажлын байр болон амралтын өрөөнд 12 төрлийн ХАБЭА-н видео хичээл байршуулж, ажилтнуудын өөрөө суралцах боломжоор хангаж байна.

Сургалтын тогтолцоо, идэвхжүүлэлт: Жил бүрийн төлөвлөгөөний дагуу ХАБЭА-н 4 төрлийн заавал зохион байгуулах сургалтыг хууль, дүрмийн хүрээнд тогтмол хийж, ажилтнуудын оролцоог дэмжин ажилладаг.

ХАБЭА-н соёлын аян: Жил бүрийн 4 болон 10-р сард тохиодог “ХАБЭА-н дэлхийн өдөр”-тэй уялдуулан Имартын бүх салбаруудад соёлын аяныг зохион байгуулж, ажилтнуудын аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх мэдлэг, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлдэг.

Аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ: Имартын бүх салбар, объектуудад аврах гарц болон аюулгүй ажиллагааны заавар, тэмдэг тэмдэглэгээг иж бүрнээр шинэчлэн байршуулж, тэдгээрийн үзэгдэх байдал, ойлгомжийг сайжруулсан.

Галын тактик сургалт: Гал түймрийн аюул, хор уршгийг таниулах, болзошгүй нөхцөл байдалд зөв хариу арга хэмжээ авах мэдлэг, чадварыг олгох зорилгоор дараах сургалтуудыг амжилттай зохион байгуулсан:

- 5 болон 6 дугаар сард Имарт Чингис болон Имарт Хороолол салбаруудад;
- Имарт Баянгол болон Имарт Хан-Уул салбарын ажилтнуудыг хамруулан 9 дүгээр сард Найрамдал зусланд нэгдсэн байдлаар зохион байгуулсан.

Энэхүү сургалтаар ажилтнууд гал түймэр, газар хөдлөлт болон бусад онцгой байдлын үед өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг хамгаалах мэдлэг, дадалд суралцдаг.

Аюулыг мэдээлэх системийн сайжруулалт: “Аюулыг мэдээлэх хуудас”-ыг цахимжуулж, QR кодоор дамжуулан мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлснээр мэдээлэх үйл ажиллагааны шуурхай байдал, ажилтнуудын идэвх, оролцоо мэдэгдэхүйц нэмэгдсэн байна.



АЖИЛТАН ТӨВТЭЙ БОДЛОГО

"Скай Хайпермаркет" ХХК нь ажилтны сайн сайхан байдал, гэр бүл, сэтгэл зүй, ур чадварын хөгжилд чиглэсэн олон талт бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, байгууллагын дотоод соёлыг “Эерэг ажилтан”-аар дамжуулан төлөвшүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна. Бид ажилтны амьдралын чанар, ажил–амьдралын тэнцвэр, эрүүл мэнд, сурч хөгжих боломжийг дэмжсэн шинэ, хүртээмжтэй шийдлүүдийг шат дараалсан байдлаар хэрэгжүүлж, ажилтнуудын сэтгэл ханамж, бүтээмжид бодит үр нөлөө үзүүлж байна. 2024 онд бид дараах бодит, хүртээмжтэй, шинэлэг санаачлагуудыг хэрэгжүүллээ:

Гэр бүлдээ зориулсан цаг

Ажил–амьдралын тэнцвэрийг дэмжих зорилгоор 3 сарын хугацаанд ажлын 5 өдрийг 4 өдөр болгон богиносгосон туршилтыг амжилттай зохион байгуулсан. Энэхүү хуваарь нь ажилтнуудын гэр бүлдээ зарцуулах цагийг нэмэгдүүлж, сэтгэл ханамжийг ахиулсан чухал туршлага болсон.

Ажилтны хүүхдүүдэд зориулсан “Хүүхдийн өрөө” үйлчилгээ

Ажилтнуудыг хүүхдээ асрах асуудлаар санаа зовохгүйгээр ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Имарт Баянгол салбар дээр хүүхдийн өдөр өнжүүлэх үйлчилгээтэй “Хүүхдийн өрөө”-г байгуулж тогтмол ажиллагаанд оруулсан. Ажилтнуудын бага насны хүүхдүүдийг аюулгүй, тогтвортой орчинд асарч, сургах зорилготой уг үйлчилгээ нь ажлын бүтээмж, ажилтны сэтгэл ханамжид өндөр эерэг нөлөө үзүүлж байна. Ирэх жилүүдэд бусад салбаруудад байгуулахаар төлөвлөж байна.

Сэтгэл зүйн дэмжлэг, зөвлөгөө

Ажилтнуудын сэтгэл зүй, амьдралын чанарт анхаарах зорилгоор “Сэтгэл зүйн эрүүл мэндийн цаг” өдөрлөг зохион байгуулж, ажилтнууд гэр бүлийн нэг гишүүний хамт оролцож сургалт, оношилгоо, зөвлөгөө авах боломжийг бүрдүүлсэн. Мөн “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”-тэй хамтран гэр бүлийн хүчирхийлэл, ажлын байрны бэлгийн дарамтаас сэргийлэх сургалт, зөвлөгөө, мэдээллийг тогтмол хүргэж байна.

Ажилтны сувилал

Зуны улиралд ажилтнууд гэр бүлээрээ амарч, эрч хүчээ сэргээх боломжийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар сувиллын дэргэд “Имарт сувиллын байр”-ыг шинээр байгуулсан. Иж бүрэн тохижуулалттай 4 өрөөтэй бөгөөд нэг ээлжиндээ

7 хоногийн хугацаанд 4 ажилтан гэр бүлийн хамт амарч, сувилуулах боломжтой. 2024 онд 17 ажилтан гэр бүлийн хамт энэ үйлчилгээнд хамрагдаж, сувилуулжээ.

Имарт Академи

Дотоод сургагч багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, 41 сургагч багшийг амжилттай бэлтгэн, “Имарт Академи”-г үүсгэн байгууллаа. Энэ нь байгууллагын ур чадварын дотоод нөөцийг бэхжүүлж, урт хугацааны хүний нөөцийн хөгжилд чухал суурь тавьж байна.

“Цалинтай ээж”, “Ажилтай ахмад”, “Орлоготой оюутан” зэрэг зорилтот бүлгүүдийн оролцоог дэмжих хөтөлбөрүүд

Хамгийн амжилттай хэрэгжсэн “Ажилтай Ахмад” хөтөлбөр нь ахмад настнуудад хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн. Уг хөтөлбөрийн мэдээлэл зөвхөн нэг телевизийн сувгаар 21,000 хүнд хүрч, 400 гаруй ахмадуудтай уулзалт зохион байгуулж, тэднээс 87 ахмад иргэнийг ажлын байраар хангасан. Энэ нь олон нийтэд нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих эерэг уриалга болж, сайн жишээ тогтоосон.

Ажилтны унаа

2024 онд Имарт Хан-Уул салбарын ажилтнуудад зориулан ажлын унааны үйлчилгээг нэвтрүүлэв. Тус салбар нь нийтийн тээврийн хүртээмж сул бүсэд байрладаг тул ажилтны өдөр тутмын зорчих нөхцлийг хөнгөвчлөх, ажлын цаг баримтлах, ядаргааг багасгах зорилгоор энэ шийдлийг хэрэгжүүлсэн.

Имарт кампинг

8 жилийн ойн хүрээнд бүх ажилтнуудад зориулсан “Emart Camping” үйл ажиллагааг хамт олны багийн уур амьсгалыг сайжруулах, хамт олны харилцааг бэхжүүлэх зорилгоор “Тэрэлж-Extreme Mongolia”–д зохион байгуулав.

Спортын Наадам

2024 оны уламжлалт “Спортын наадам”-ыг 8 төрлийн тэмцээнтэйгээр амжилттай зохион байгуулж, Имартын аварга баг болон компанийн шигшээ багийг шалгаруулсан.


Мэдлэгээ хуваалцъя

Хэлтэс, нэгжүүдийн уялдаа холбоог бэхжүүлэх зорилгоор “Мэдлэгээ хуваалцъя” цуврал уулзалтыг 26 долоо хоног дараалан зохион байгуулсан.

Нийгмийн хариуцлага ба хамтын үнэ цэн — Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал — Ажилтан төвтэй бодлого — Олон талт байдал, тэгш боломж — Сургалт ба ажилтны хөгжлийн хөтөлбөр —
Ханган нийлүүлэлтийн тогтвортой байдал, хамтын үнэ цэн — Чанар ба хүнсний аюулгүй байдал — Нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөлөл

ОЛОН ТАЛТ БАЙДАЛ, ТЭГШ БОЛОМЖ

“Скай Хайпермаркет” ХХК нь ажиллах хүчний олон талт байдлыг дэмжих, хүн бүрт тэгш боломжийг хангах орчныг бүрдүүлэхийг тогтвортой хөгжлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг хэмээн үздэг. Компанийн хүний нөөцийн бодлого нь хүйс, нас, үндэс угсаа, эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлог, гэр бүлийн байдал, итгэл үнэмшил, нийгмийн байдал зэргээс үл хамааран ажилтнуудад тэгш эрхтэй, аюулгүй, хүндлэлтэй хөдөлмөрийн орчин бүрдүүлэхэд чиглэж байна.



СУРГАЛТ БА АЖИЛТНЫ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР

“Скай Хайпермаркет” ХХК нь ажилтны ур чадвар, мэргэжлийн өсөлт, хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор шаталсан сургалт хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байна. Компанийн сургалт, хөгжлийн бодлого нь ажилтныг зөвхөн тухайн албан тушаалд тохирох чадвартай байлгахаас гадна ирээдүйн удирдагч, мэргэшсэн мэргэжилтэн болгон төлөвшүүлэх зорилготой юм.

Сургалтыг дараах таван чиглэлд хуваан хэрэгжүүлж байна:

Дасан зохицох хөтөлбөр – Шинэ ажилтныг богино хугацаанд компанийн соёлд уусгах, ажлын байрандаа дасах.

Ур чадварын сургалт – Албан тушаал бүрд шаардлагатай үндсэн ур чадвар олгох.

Карьер өсөлтийн хөтөлбөр – Дараагийн түвшинд дэвшихэд шаардлагатай чадварыг эзэмшүүлэх.

Захиалгат сургалт – Нарийн мэргэшлийн ур чадвар эзэмшүүлэх.

Байгууллага хөгжүүлэлтийн хөтөлбөр – Байгууллагын соёлыг бэхжүүлж, ажилтны эрүүл мэнд, санхүүгийн мэдлэгийг нэмэгдүүлэх.

Нэмэлтээр, чиглүүлэх хөтөлбөр, үндсэн чадамжийн сургалт, хөгжүүлэх хөтөлбөр, идэвхжүүлэх хөтөлбөр зэрэг нь шинэ ажилтныг тогтвор суурьшилтай ажиллахад түлхэц үзүүлдэг.

2024 онд давхардсан тоогоор нийт 3,020 ажилтан сургалтад хамрагдсан бөгөөд үүнээс 1,044 ажилтан нь ХАБЭА-ийн сургалтад хамрагдсан байна. Ажилтны дундаж сургалтын цаг 5.5 цаг байв.

Сургалтыг компанийн дотоод сургагч багш нар болон гэрээт сургагчид хариуцан зохион байгуулж, хүний нөөцийн менежер хэрэгжилтэд хяналт тавин удирдлагад тайлагнадаг.

Ажилтнууд батлагдсан сургалтад хамрагдаж буй хугацаандаа цалинтай чөлөө авах эрхтэй бөгөөд олон жил тогтвортой ажилласан, карьерын өсөлттэй ажилтнуудад мэргэжил эзэмших, мэргэжил дээшлүүлэх тэтгэлэг, хөнгөлөлт, зээл олгодог. Дотоод боломж хүрэлцээгүй тохиолдолд компанийн зүгээс гадны мэргэжлийн байгууллагатай хамтран гүнзгийрүүлсэн сургалт явуулдаг. 2024 оны байдлаар гадны байгууллагуудаас нийт 45 ажилтан консалтинг, мэргэшлийн сургалтад хамрагдсан байна.

2024	
Ажилтны сургалтын бүртгэл /нийт цаг/	18,978
Эрэгтэй	5,693
Эмэгтэй	13,285
Ажилтны жилийн дундаж сургалтын цаг	5,5
Эрэгтэй	1,7
Эмэгтэй	3,85

Байгууллагаас зохон байгуулсан нийт сургалтын тоо /Давхардсан тоогоор/	
3020	

Гадны сургалтад мэргэжил дээшлүүлсэн ажилтны тоо	
45	27,7%

ХАБЭА сургалтанд хамрагдсан ажилтны тоо/хувь	
1044	83,7%



ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ХАМТЫН ҮНЭ ЦЭН

“Скай Хайпермаркет” ХХК нь нийгэм, эдийн засаг, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх, ёс зүйтэй, хариуцлагатай бизнесийн түншлэлийг дэмжих зорилгоор ханган нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог үе шаттайгаар бүрдүүлэн хэрэгжүүлж байна. Бид нийлүүлэлтийн бүх үе шатанд шударга, ил тод, тогтвортой зарчмуудыг баримталж, оролцогч талуудтайгаа харилцан ашигтай, урт хугацааны хамтын үнэ цэнийг бий болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлдэг.

Энэхүү тогтолцоо нь компанийн ёс зүйн дүрэм, худалдан авалтын журам, гэрээт түнш сонгон шалгаруулах шалгуур, шинэ харилцагч, түрээслэгчийн үнэлгээ, гэрээний гүйцэтгэлийн хяналт, хэрэглэгчийн санал гомдлыг шийдвэрлэх тогтолцоо, “Өртөө” цахим систем зэрэг баримт бичиг болон платформд тулгуурладаг. Шинэ харилцагч, түрээслэгчийг сонгохдоо тухайн байгууллагын өрсөлдөх чадвар, хууль эрх зүйн байдал, бараа бүтээгдэхүүний онцлог, санхүүгийн тогтвортой байдал зэрэг шалгуур үзүүлэлтээр үнэлж, нийт онооны 80 хувиас дээш үнэлгээ авсан тохиолдолд хамтын ажиллагаа эхлүүлдэг. Түүнчлэн, цэвэрлэгээ, хамгаалалт, катеринг зэрэг үйлчилгээг аутсорсинг хэлбэрээр гэрээ байгуулан хэрэгжүүлдэг ба түнш байгууллагуудын үйлчилгээний туршлага, ажиллах хүчний хангалттай байдал, хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдлын шалгуурт үндэслэн сонгон шалгаруулалт хийгддэг.

“Өртөө” цахим систем нь бараа бүртгэл, захиалга, төлбөр тооцоо, үнийн мэдээллийг харилцагчидтай шуурхай солилцох боломжийг бүрдүүлсэн бөгөөд жижиг, дунд бизнес эрхлэгчид нөөцөө оновчтой удирдах, борлуулалтаа нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Мөн мэдээллийн ил тод байдлыг хангаж, харилцагчийн туршлагыг сайжруулж буй үндсэн платформ болж байна.

Дотоодын үйлдвэрлэгчдийн дэмжлэг, үндэсний үйлдвэрлэлд оруулж буй хувь нэмэр:

- “Хөх шошго” хөтөлбөрийн хүрээнд эхэлсэн цагаасаа хойш дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг худалдаалж, үндэсний үйлдвэрлэлийн тэлэлт, хэрэглэгчдэд хүрэх сувагт бодит хувь нэмэр оруулж байна.
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд орон нутгийн тариаланчдад зориулан нийлүүлэлтийн сүлжээний талаар мэдээлэл өгөх уулзалт зохион байгуулж, шинэ төрлийн нарийн ногоо, жимсийг нутагшуулах ажил амжилттай эхэллээ.

- Дотоодын үйлдвэрлэгчидтэй хамтран Bella Casa, Home-Pro, UniQ, Түмний Үнэ, Made4U зэрэг хэрэглэгчийн зан төлөв, амьдралын хэв маягт нийцсэн in-house брэндийг хөгжүүлж, 74 харилцагчаас 2,322 нэр төрлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэн, борлуулсан байна. Зөвхөн 2024 онд 1,560 нэр төрлийн бүтээгдэхүүнийг шинээр хөгжүүлсэн байна.

Гадаад харилцаа, олон улсын худалдаа:

“Скай Хайпермаркет” ХХК нь 2024 оны байдлаар “Скай Хайпермаркет” ХХК нь гадаад, дотоодын нийт 919 харилцагчтай хамтран ажиллаж байна. 20 гаруй орны 300 гаруй түншээс импортын бүтээгдэхүүн авч, албан ёсоор борлуулдаг бөгөөд шинээр:

- Bridor, Kühne, Asbal, Binggrae, Cachet, Sweet, Switch хүнсний бараа;
- Starlink, Topten10, Molly’s, Trefl, Roichen, Downy зэрэг хүнсний бус барааны олон улсын брэндийн 2,435 нэр төрлийн шинэ бүтээгдэхүүнийг импортлов. Эдгээр шинэ брэндүүд нь хэрэглэгчийн сонголтыг өргөжүүлж, компанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан.

Мөн БНСУ-ын Гёнсанбүг аймаг, “Nonghyup” байгууллага, “Mr. Papa” компанитай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан хүнсний гаралтай бүтээгдэхүүний худалдаа, сав баглаа боодол, ложистикийн чиглэлээр хамтран ажиллаж байна.

Олон улсын сайн туршлага, стандарт нэвтрүүлэлт:

Нийлүүлэлтийн сүлжээний хариуцлагатай, ил тод байдлыг сайжруулах хүрээнд “Скай Хайпермаркет” ХХК нь тогтвортой ханган нийлүүлэлтийн тогтолцоогоо сайжруулаж олон улсын түвшинд хүргэх зорилгоор ISO 20400:2017 Тогтвортой худалдан авалтын зөвлөмжийг нэвтрүүлэхээр төлөвлөөд байна.



ЧАНАР БА ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

“Скай Хайпермаркет” ХХК нь Имарт сүлжээ дэлгүүрээр дамжуулан хэрэглэгчдэд хүрч буй хүнсний бүтээгдэхүүн, хоол үйлдвэрлэл, хагас боловсруулсан бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд өндөр хяналт тавин ажилладаг. Манай компанийн чанарын тогтолцоо нь үндэсний хууль тогтоомж, олон улсын стандартуудтай уялдсан, тогтмол сайжруулалт бүхий систем юм.

MNS ISO/IEC 17025:2018 стандарттай итгэмжлэгдсэн лаборатори

Бүтээгдэхүүний аюулгүй байдлыг баталгаажуулах зорилгоор “Скай Хайпермаркет” ХХК нь химийн болон микробиологийн шинжилгээг системтэй, төлөвлөгөөт байдлаар хийдэг. Манай хими, микробиологийн лаборатори нь MNS ISO/IEC 17025:2018 стандартын итгэмжлэлтэй бөгөөд:

Микробиологи: 11 төрлийн 25 категорын бүтээгдэхүүнд 185 үзүүлэлт

Хими: 9 төрлийн 25 категорын бүтээгдэхүүнд 133 үзүүлэлтийн хүрээнд шинжилгээ хийдэг. Лабораторийн үйл ажиллагаа нь мэргэжлийн баг бүрэлдэхүүн, 53 төрлийн тоног төхөөрөмж, 99 нэр төрлийн баталгаажсан урвалж бодистой, жил бүр СХЗГ-аар тоног төхөөрөмжөө баталгаажуулан ажилладаг.

Дотоод хяналт ба эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ

Чанар хяналтын хэлтэс нь компанийн бүх үндсэн болон түрээс шимтгэлийн ААН-үүдэд хуваарийн дагуу тодорхой давтамжтай төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт хийж, илэрсэн үл тохирлыг залруулах арга хэмжээг авч ажилладаг. Ажлын байрны орчны эрүүл ахуйг хянаж, өдөр тутмын цэвэрлэгээ ариутгал, агаарын харьцангуй чийг, температурт өдрийн 3 удаагийн давтамжтай хяналт тавьж, бүртгэл хөтлөлтөөр баталгаажуулдаг. Хүнсний бүтээгдэхүүнийг гардан бэлтгэдэг, түүгээр үйлчилдэг ажилтнуудыг жилд 2 удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулдаг.

Бэлтгэн нийлүүлэгч болон үйлдвэрт тавих хяналт

Гэрээ байгуулахаас өмнө шаардлагатай тохиолдолд “Factory Audit” хийж, ажлын орчин, тоног төхөөрөмж, эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг үнэлдэг. Илэрсэн үл нийцлийг бүрэн залруулсны дараа гэрээ байгуулдаг. Гэрээт харилцагчаас түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авахдаа чанар аюулгүй байдлыг баталгаажуулсан лабораторийн сорилын дүгнэлт, гарал үүслийн хамт хүлээн авч худалдан борлуулдаг.

Ариутгал, халдваргүйтгэл ба хортон шавж устгал

Салбар дэлгүүрүүдэд улирал тутам мэргэжлийн гэрээт байгууллага болох “Цэвэр-Орчин” ХХК, “Улаанбаатар ариутгал” ХХК-тай хамтран агаарын ариутгал, шавжгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн ажлын зохион байгуулдаг.

Сургалт, чадавхжуулалт

Компанийн үндсэн ажилтнууд болон түрээс, шимтгэлийн айлуудад “Food Safety Manual”, “Чанартай бараа хүлээн авах”, “Импортын бараанд шошго наах журам”, “Хадгалах хугацааны стөндөрт”, “Органик хүнсний тухай ойлголт”, “ЧХХ-ын баримт бичиг хүлээн авах” багц сургалтуудыг сар, улирлын давтамжтайгаар зохион байгуулдаг.

Хэрэглэгчийн санал, гомдол хүлээн авах ба шийдвэрлэх

Чанар аюулгүй байдалтай холбоотой хэрэглэгчийн санал, гомдлыг “Хэрэглэгчийн санал гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагааны журам”-ийн дагуу “Low”, “Medium” гомдлыг 3 хоногийн дотор, “High risk” буюу хоолны хордлого, харшил, гадны биеттэй холбоотой гомдлыг 5 хоног батгаан шийдвэрлэдэг. Мэргэжлийн эрх бүхий байгууллагын албан шаардлага, даалгавар, лабораторийн сорилын дүгнэлт шаардлагатай, онцгой тохиолдолд гомдлын шийдвэрлэх хугацаа 1 сар хүртэл сунгагдах боломжтой. Энэ тохиолдолд компанийн зүгээс хэрэглэгчид мэдээлэл өгч, явцыг тогтмол тайлагнадаг хугацаа 1 сар хүртэл сунгагдах боломжтой байдаг. Энэ тохиолдолд компанийн зүгээс хэрэглэгчид мэдээлэл өгч, явцын тайланг тогтмол хүргэдэг.



НИЙГЭМД ҮЗҮҮЛЖ БУЙ ЭЕРЭГ НӨЛӨӨЛӨЛ

“Скай Хайпермаркет” ХХК нь бизнесийн өсөлт, тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулан нийгмийн хариуцлагыг үндсэн үнэт зүйл болгон хэрэгжүүлдэг. Бид ажилтнуудын сайн сайхан байдлыг дэмжихийн зэрэгцээ нийгмийн бүх түвшинд – олон нийт, хүүхэд, залуусын боловсрол, тэгш оролцоо, байгальд ээлтэй дадал, хамтын оролцоо зэрэг салбарт бодит хувь нэмэр оруулсаар байна. 2024 онд нийт 110 сая төгрөгийн санхүүжилттэйгээр 20 гаруй төсөл, санаачилгыг амжилттай хэрэгжүүлж, нийгэмд эерэг нөлөө үзүүлсэн он жил байлаа.

- Олон нийтийн сайн сайхны төлөөх хамтын оролцоо**
- *Хамтдаа цас цэвэрлэгцгээе аян* – 360 гаруй ажилтан сайн дурын үндсэн дээр нийслэлийн томоохон эмнэлгүүдийн гаднах талбайг цэвэрлэж, орчны аюулгүй байдал, олон нийтийн оролцоог дэмжив.
 - *Гамшгийн үед дэмжлэг үзүүлэх* –Галын осолд өртсөн үндэсний үйлдвэрлэгч “НВЦ”-ийн “Баян” үйлдвэрт тусламж үзүүлэв.
 - *Энхийг сахиулагчдын гэр бүлд дэмжлэг* – Онцгой байдлын болон энхийг сахиулагчдын гэр бүл, хүүхдүүдэд гарын бэлэг гардуулж, амьдралд нь халуун дотно уур амьсгал нэмэхийг зорилоо.

- Хүүхэд, боловсрол ба соён гэгээрүүлэх санаачилга**
- 5 өнгийн аян – Бага, дунд, ахлах ангийн сурагчдад зориулсан эрүүл, зөв хооллолт, танин мэдэхүй, сэтгэл зүй, байгаль хамгааллын чиглэлийн сургалт, өдөрлөг, подкаст зэрэг цогц боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлж, ирээдүйн иргэдэд чиглэсэн мэдлэг, хандлагыг төлөвшүүлэв:
- *Зөв хооллолтын тухай сургалт (бага анги)*
 - *“Цоохор ирвэс” подкаст болон танин мэдэхүйн өдөрлөг (дунд анги)*
 - *Нөхөн үржихүйн боловсрол ба сэтгэл зүйн мэдлэг (ахлах анги)*

- Аав, ээжийн ажилтай танилцах өдөрлөг**
- Аав ээжийн ажилтай танилцах өдөрлөгийг тохиолдуулан 2024 оноос эхлэн ажилтнуудын хүүхдүүдэд 10 минутын байгаль хамгаалал, тогтвортой хөгжлийн товч танилцуулгыг хийж эхлэв.

- Энэ сарын эрүүл гэр бүл аян**
- “Koica Mongolia”-тай хамтран хэрэгжүүлсэн уг аянд 1,800 гаруй хүүхэд хамрагдаж, зохистой хооллолт, эрүүл амьдралын талаарх мэдлэг олж авсан.

- Дэлхийн Хүүхдийн Эрхийн Өдөр – 11 дүгээр сарын 20**
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын гол заалтуудыг салбар дэлгүүрүүдийн LED дэлгэцээр олон нийтэд түгээж, хэрэглэгчдэд хүүхдийн эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэн, хүүхдийн сайн сайхны төлөө хамтын хариуцлага хүлээх уриалгыг түгээв.

- Happy Children’s Day өдөрлөг**
- Олон нийтэд зориулсан энэхүү баярын өдөрлөгөөр дамжуулан хүүхдүүдийн оролцоог урамшуулж, хамтдаа баярлах боломжийг салбар бүрт бүрдүүлсэн.

- Korea Week & Visit Korea Year 2024**
- БНСУ-ын элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан энэ өдөрлөгийн үеэр хуванцар хаягдлыг ангилан ялгах, гялгар торноос татгалзах дадлыг олон нийтэд сурталчлан, олон дахин ашиглах эко торны хэрэглээг нэмэгдүүлж, хариуцлагатай хэрэглээг дэмжих үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдсан. K-Pop соёл, олон нийтийн оролцоог хослуулсан эдгээр өдөрлөг нь ногоон хэрэглээний үзэл баримтлалыг залуу үеийнхэнд түгээсэн онцлох санаачилга байв.

- Спорт, оюуны хөгжлийг дэмжих хөтөлбөрүүд**
- “Скай Хайпермаркет” ХХК нь хүүхэд, залуусын оюуны болон биеийн хөгжлийг тэгш дэмжих зорилгоор дараах спортын болон тэмцээн уралдаануудыг ивээн тэтгэж, оролцоог нэмэгдүүлсэн. Үүнд:
- *Суугаа волейболын тусгай хэрэгцээт тамирчдыг дэмжив;*
 - *Олимпын мөнгөн медальт тамирчинд урамшуулал олгов;*
 - *Өсвөрийн даамын ДАШТ болон уран сайхны гимнастикийн хүүхдүүдийг дэмжих хандив, бэлгийн багц гардуулав.*

2024 онд бид хүүхдийн боловсрол, байгаль орчны боловсрол, тэгш оролцоо, хариуцлагатай хэрэглээг төлөвшүүлэх олон талт, бодит үр дүнтэй нийгмийн хариуцлагын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхны төлөө бизнесийн бодит хувь нэмрээ оруулсан он жил байлаа.

Цаашид ч бид “нийгэмд эерэг нөлөө үзүүлэгч” байгууллага байх үүргээ улам бүр бэхжүүлэн ажиллана.

Засаглал

Төлөөлөн удирдах зөвлөл

32

Гүйцэтгэх удирдлага

33

Хариуцлагатай манлайлал

34



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ

ТУЗ-н дарга



Б.БАТТУШИГ

ТУЗ-н гишүүн



Б.САМАДИ

ТУЗ-н гишүүн



Б.БАДАМХАНД

ИМАРТ ИНК-н гишүүн



Ж.Г.ЧОЙ

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

**Л.ЖАВЗМАА**

Гүйцэтгэх захирал

**ЖИН НАМ КЮУ**Хамтын ажиллагаа
хариуцсан захирал**Д.МАШБАТ**Гүйцэтгэх захирлын Бизнес
эрхэлсэн орлогч бөгөөд
Худалдаа эрхэлсэн дэд захирал**Б.БОЛОРМАА**Санхүү, хөрөнгө оруулалт
эрхэлсэн дэд захирал**М.ДОРЖЛХАГВА**Хөрөнгө хөгжүүлэлт
эрхэлсэн дэд захирал**Э.ХАЛИУН**Захиргаа, хүний нөөц
эрхэлсэн дэд захирал**З.БААСАНЖАРГАЛ**Борлуулалт, үйлчилгээ
эрхэлсэн дэд захирал**Т.АЛТАНХУНДАГА**Маркетинг, үйлчилгээ
эрхэлсэн дэд захирал

ХАРИУЦЛАГАТАЙ МАНЛАЙЛАЛ

Шударга, ёс зүйт засаглал бол урт хугацааны амжилтын баталгаа

“Скай Хайпермаркет” ХХК нь ёс зүй, ил тод байдал, оролцоо, шударга манлайллыг компанийн засаглалын гол үнэт зүйл болгон ажилладаг. Бид засаглалыг зөвхөн бүтцийн тогтолцоо биш, харин хэрэглэгч, ажилтан, хувьцаа эзэмшигч, оролцогч талуудын итгэлцлийг бий болгогч үндсэн суурь гэж үздэг.

2024 оны онцлох ажлууд:

- Төлөөлөн удирдах зөвлөлд анх удаа эмэгтэй гишүүн томилогдож, жендэрийн харьцаа 25%, 75% боллоо. Энэ нь шийдвэр гаргах түвшинд тэгш оролцоог хангах чиглэлд хийсэн бодит алхам байв.
- Microsoft 365 системийг нэвтрүүлснээр баримт бичгийн хяналт, шийдвэрийн ил тод байдал, дотоод мэдээллийн нэгдмэл байдал, аюулгүй ажиллагааг бүх түвшинд бэхжүүлэв.
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж, дотоод хяналт, нууцлал, зөвшөөрөлд суурилсан хандалтын бүтэц бүрдүүлсэн.
- Эмэгтэй эзэмшигчтэй байгууллагуудын тусгай бүртгэлийг ханган нийлүүлэлтийн бодлогод тусгаж, жендэрийн мэдрэмжтэй худалдан авалтыг эхлүүлэв.
- Монголын “Тогтвортой Санхүүжилтийн Холбоо”-нд гишүүнээр элсэж, ногоон болон хариуцлагатай бизнесийн засаглалын шинэ хандлагад идэвхтэй нэгдэв.
- Монголын ҮХАҮТ болон Голомт банктай хамтран “Women-Owned” санаачилгад нэгдэж, эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих гурван талт хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан бөгөөд 2025 бодитоор хэрэгжүүлэхээр боллоо.
- Гүйцэтгэх захирал Л.Жавзмаа хувийн манлайллаар бүтээгдэхүүний тээвэрлэлт, маркетинг, хэрэглэгчтэй харилцах арга барилын зөвлөгөө өгч, менторшип хандлагаар бодит дэмжлэг үзүүлэв.
- Тогтвортой байдлын тайлагналын үйл явцыг анх удаа хэрэгжүүлж, БОНЗ-ын суурь үнэлгээнд үндэслэсэн нэгдсэн тайлангаа олон нийтэд нээлттэй танилцууллаа.



Засаглалын тулгуур 5 чиглэл:

1. Ил тод байдал ба хариуцлагын тогтолцоо Улирал тутмын ТУЗ-ийн хурлууд, шийдвэрийг бүртгэлжүүлэн, төлөвлөлт, эрсдэл, гүйцэтгэлийг хамтын хэлэлцүүлгээр шийдвэрлэдэг. БНСУ-ын “Имарт” компани нь ТУЗ-д төлөөлөгч томилж, стратеги, санхүүгийн гүйцэтгэлд тогтмол хяналт тавьдаг. Хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу чухал шийдвэрүүдийг 100%-ийн зөвшилцлөөр гаргадаг.

2. Ёс зүй ба шударга байдал “Ёс зүйн дүрэм”, гэрээний зохицуулалт, сургалт, зөвлөмжөөр дамжуулан авлига, сонирхлын зөрчлийг хянан ажиллаж байна. Шүгэл үлээгчийн хамгаалалт, дотоод гомдлын нууцлалтай системийг хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

3. Мэдээллийн аюулгүй байдал ба дижитал шилжилт Microsoft 365, ERP болон мобайл платформуудыг ашиглан мэдээлэл, үйл явцыг цахимжуулж, эрх бүхий хандалтаар нэвтрүүлж байна. Ажилтны цалин, үнэлгээ, урамшуулал, гомдол саналын мэдээллийг мобайл апп-аар аюулгүй хүргэж байна.

4. Хувьцаа эзэмшигч ба хөрөнгө оруулагчийн хяналт БНСУ-ын “Имарт” компани, “Чингисхаан Адвентурс” ХХК, “Скай Трейдинг” ХХК хооронд байгуулсан гэрээний хүрээнд компанийн зорилго, хувьцаа шилжүүлэлт, хөрөнгийн хэлцэл зэргийг 100%-ийн зөвшилцлөөр шийдвэрлэдэг. Хувьцаа эзэмшигчдийн хяналтын тогтолцоо нь гэрээ, дүрэмд суурилсан, хариуцлагатай шийдвэрийн механизмтай.

5. Оролцогч талуудын оролцоо ба итгэлцэл 7611-0101 дугаар, чатбот, зөвлөмжийн апп, сошиал сувгууд ашиглан хэрэглэгч, ажилтны гомдол, саналыг дижитал хэлбэрээр хүлээн авч шийдвэрлэдэг. 2024 онд ажилтнуудаас нийт 1,500 өргөдөл, санал, гомдол, хүсэлт, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэсэн.

“Скай Хайпермаркет” ХХК нь ёс зүйтэй, тэгш оролцоог эрхэмлэсэн засаглалын тогтолцоог төлөвшүүлж, Монголын жижиглэн худалдааны салбарт хариуцлагатай бизнесийн манлайллыг бий болгож байгаа гэдэгт итгэлтэй байна. Бид засаглалыг зөвхөн удирдлагын хэрэгсэл гэж үзэхээс илүүтэйгээр компанийн ёс суртахуун, шударга зарчим, хамтын үнэ цэн, бизнесийн нэр хүндийн илэрхийлэл гэж ойлгож өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

Тогтвортой байдлын гүйцэтгэл

Тогтвортой хөгжлийн зорилготой
уялдах нь






36



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДАХ НЬ

НҮБ-ын санаачлан хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) нь хүн төрөлхтнийг илүү сайхан, тогтвортой ирээдүйд хүргэхийн тулд хөгжлөөс хэнийг ч үл хоцроож, үлдээхгүйн төлөөх чин эрмэлзэлд тэмүүлсэн дэлхий нийтийн, хамтын хүчин чармайлт юм. Даян дэлхийн улс орон бүр амлалт өгсөн ТХЗ-ын баримт бичиг нь 17 зорилго, 169 зорилтын хүрээнд ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, энх тайван, шударга ёс

зэрэг сорилтуудыг авч үздэг. ТХЗ-ыг биелүүлэхэд бүх оролцогч талуудын үүрэг амлалт, хүчин чармайлт чухал бөгөөд Скай Хайпермаркет ХХК нь бизнесийн стратеги, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан хамгийн их нөлөө үзүүлж байна. БОНЗ-ын гүйцэтгэлийг сайжруулснаар ТХЗ-ын хэрэгжилтэд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх бүрэн боломжтой.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДАХ НЬ

**Ядуурлыг устгах**

Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих

2024 онд **50+** үндэсний ханган нийлүүлэгчтэй гэрээ байгуулсан.

**Өлсгөлөнг зогсоох**

Чанартай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх

Жилд **20,000** тонн хүнсний бүтээгдэхүүн борлуулсан.

**Эрүүл мэндийг дэмжих**

Эрүүл мэндийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх

2024 онд нийт **500+** ажилтанд эрүүл мэндийн үзлэг зохион байгуулсан.

**Чанартай боловсролыг дэмжих**

Сургалт зохион байгуулах

2024 онд ажилтнуудаа тогтмол **3020** академик цагийн сургалтад хамруулж, **45** ажилтан гадаад сургалтад хамрагдсан.

**Жендерийн тэгш байдлыг хангах**

Эмэгтэй ажилтнуудаа өргөжүүлэн дэмжих

Ажиллах хүчний төлөөллийн **59%** нь эмэгтэй, удирдлагын түвшинд **64%** нь эмэгтэй.

**Баталгаат усан хангамж, ус ариун цэврийн байгууламжийг хангах**

Ус хэмнэх шинэчлэл

Ус хэмнэлтийн 2023 онтой харьцуулахад **15%**-аар бууруулсан.

**Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх**

Эрчим хүчний хэмнэлтийн технологи ашиглах

Жилд **1.2 сая кВт.ц** эрчим хүч хэмнэсэн.

**Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих**

Ажлын байр нэмэгдүүлэх

2024 онд нийт **200+** шинэ ажлын байр бий болсон.

**Инноваци ба дэд бүтцийг хөгжүүлэх**

Шинэ технологи нэвтрүүлэх

2024 онд 5 салбар дэлгүүр **өөртөө үйлчлэх касс** нэвтрүүлсэн.

**Тэгш бус байдлыг бууруулах**

Орон нутгийн ханган нийлүүлэгчдийг дэмжих

Нийт бүтээгдэхүүний **30%** орон нутгийн гаралтай.

**Ээлтэй хот, ногоон орчныг дэмжих**

Ногоон байгууламж нэмэгдүүлэх

Дэлгүүрийн гадна зүлэгжүүлсэн талбайн **20%**-ийг ногоон байгууламж эзэлдэг.

**Хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэл**

Хог хаягдал багасгах

Хог хаягдал 2023 онтой харьцуулахад **10%**-иар бууруулсан.

**Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах**

Карбон хийн ялгарлыг бууруулах

2024 онд **1515.2** тонн нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулсан.

**Хуурай газрын экосистемийг хамгаалах**

Мод тарих аян

2024 онд **1,800** мод тарьсан.

Хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН




Скай Хайпермаркет ХХК нь ISO 14001:2015, ISO 45001:2018 нэгдсэн менежментийн тогтолцоог амжилттай нэвтрүүлэн баталгаажуулалтын гэрчилгээгээ 2024 оны 10-р сарын 23-ны өдөр гардан авлаа.



Имарт Баянгол салбарын дээвэрийн нийт 4 байршилд Моно төрлийн /Bifacial/ 660Вт чадалтай 2 талдаа нарны элементтэй 48 ширхэг нарны хавтанг сууриллаа.



Гидропоник технологиор нэг удаагийн тариалалт буюу 42-45 хоногийн нэг циклд нийт 42,750 ш суулгац тариалах хүчин чадалтай бөгөөд суулгацыг 85%-тай ургуулаад нэг булцууны дундаж 100 гр хүрэхэд 1 циклд 3,6 тн салат навчийг зах зээлд нийлүүлэх боломжтой.



2 салбар дэлгүүрт Модулар хайрцгийг байрлуулал 800 кг хүнсний хаягдлыг дахин боловсруулан бордоо болгох туршлага амжилттай хэрэгжлээ.

НИЙГЭМ



ISO 45001:2018 стандарт нэвтрүүлэлт:
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн
стандартыг нэвтрүүлснээр ажилтны эрсдэл буурч,
ажлын орчны таатай нөхцөл бүрдсэн.



“Орлоготой оюутан”, “Ажилтай ахмад”, “Цалинтай эмэгтэй” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн тэтгэвэртээ гарсан ахмад, хүүхдээ хардаг ээжүүд, оюутнуудаас туршлага шаардахгүй уян хатан цагийн нөхцөлтэй ажлын байраар хангах хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүллээ.



“Улаанбаатар сувилал”-тай хамтран, ажилтнууддаа зориулан гэр бүлээрээ хамтдаа сувилуулах боломжтой судилалыг байрыг бүрэн тохижуулж ашиглалтад орууллаа.



“Монгол хүн та 100 наслаг...” уриан дор нийт ажилтнууд болон тэдний гэр бүлийн эрүүл мэндэд анхааран “Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн”-тэй хамтран “Mental Health Time” сэтгэл зүйн өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа.



Ажилтнуудаа сурч хөгжих боломжоор дэмжих, хамтдаа тасралтгүй хөгжих зорилгоор “Имарт Монгол Академи”-ийг байгуулж амжилттай төгссөн анхны “Сургагч багш” нартаа батламж гардууллаа. Ингэснээр компанийн хэмжээнд ерөнхий болон заах арга зүйн ур чадвараар мэргэшсэн 41 “Сургагч багш”-тай боллоо.




HORECA, уул уурхай, катеринг, хүнсний үйлдвэрлэл зэрэг салбарын байгууллагуудад зориулсан Имарт Бизнес Клуб-ийн платформтой боллоо.

НИЙГЭМ



Имартын хамт олон нийгмийн хариуцлагын хүрээнд 360 ажилтнуудынхаа оролцоотойгоор “ХАМТДАА ЦАС ЦЭВЭРЛЭЦГЭЭ” аяныг зохион байгууллаа.

Шинэ оны анхны сайн үйлсийн аяныг олны хөл хөдөлгөөн ихтэй “Улсын Хоёрдугаар төв эмнэлэг”, “Гэмтэл согог судлалын үндэсний төв”, “Хавдар судлалын үндэсний төв” болон “Улсын Гуравдугаар төв эмнэлэг”-үүдийн нийт 1,800м² талбай бүхий явган хүний замын дагтаршсан цас мөсийг цэвэрлэлээ.



Амьтдын ертөнц “Уулын эзэн цоохор ирвэс” подкаст



5 өнгийн аян – 2024

“Монгол хүн Та 100 наслаг” уриан дор хүүхдүүдэд эрүүл, зөв хооллолтыг дэмжих хоол зүйн боловсрол, ухаалаг сонголт, хэрэглээний соёлыг таниулах, хэвшүүлэх зорилгоор сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд 5 өнгийн жимсний сургалтыг 2017 оноос хойш тогтмол зохион байгуулж байна. Тус сургалтаар өнгө өнгийн жимс, ногооны ашиг тусыг таниулан, хэрэглээнд сургахаас гадна тэднийг ирээдүйн ёс зүйтэй үйлчлүүлэгч болоход нь тусалж, худалдан авалтын боловсролын анхан шатны ойлголтыг өгөхийг зорьдог.



“БИ ХЭН БЭ?” бэлгийн боловсролын талаар мэдлэг олгох сэтгэл зүйн сургалт /Ахлах ангийн сурагчид/



“Ирвэс Хамгаалах Өдөр” /Дунд ангийн сурагчид/



“Koica Mongolia” ОУБ-ын хамтын ажиллагааны хүрээнд “Энэ сарын эрүүл гэр бүл” аяныг 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

НИЙГЭМ



Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд хийсэн онцлох үйл ажлаа хүртээмжтэй, ил тод байдлыг хангах зорилгоор 2D animation болгон тайлагнав.



“Монголын суугаа волейболын холбоо” “БНСУ-ын Өмнөд Чунчон мужийн Борёонгын тусгай хэрэгцээт иргэдийн волейболын холбоо”-той хамтын ажиллагааны хүрээнд Монгол улсад 2 улсын баг тамирчдын нөхөрсөг тоглолт хийсэн. Тэдний үйл ажиллагааг дэмжин бид нийгмийн хариуцлагын хүрээнд БНСУ-аас ирсэн тусгай хэрэгцээт 22 тамирчдад бэлэг гардуулав.




100-н буудалт даамын Өсвөрийн залуучуудын Дэлхийнаваргашалгаруулах тэмцээнд 7~18 насны 29 тамирчдынхаа амжилтыг хамтдаа тэмдэглэв.



Монголын Гимнастикийн Холбооны Уран сайхны гимнастикийн “Шитгээ” клубын 300 тамирчин хүүхдүүдээ дэмжив.



Олимпын мөнгөн медаль хүртсэн Б.Баасанхүү тамирчныхаа алдрыг мялаав.



Korea Week - 2024 үйл ажиллагаанд оролцож “Эх дэлхийгээ хайрлах” уриалгыг дэвшүүлэн “No Brand”, “Innisfree” брэнд бүтээгдэхүүний хуванцар савнуудыг ангилан хаях дадалд уриалсан. Мөн гялгар торноос татгалзаж олон удаа ашиглах боломжтой эко торны хэрэглээг бодитоор сурталчлан таниулсан.



Мөн тухайн арга хэмжээний үеэр Giveway зарлаж K-Pop тоглолтын 30 тасалбарын эздийг тодрууллаа

ГИШҮҮНЧЛЭЛ БОЛОН ШАГНАЛ

	ШАГНАЛ	ХУГАЦАА
Entrepreneur	Онцлох хөрөнгө оруулагч	2017
Entrepreneur	Дотоодын ханган нийлүүлэгчдийг дэмжигч	2018
Entrepreneur	Худалдааны салбарын онцлох энтрепренер	2019
Entrepreneur	Сайн засаглалыг хэрэгжүүлэгч	2021
Entrepreneur	Ази, Номхон далайн орнуудын ХАҮТ-уудын Нэгдсэн Холбооны “Silver Mercury” шагнал	2023
Топ 100 ААН	98 дугаар байр	2016
	72 дугаар байр	2017
	63 дугаар байр	2018
	40 дүгээр байр	2020
	31 дүгээр байр	2021
	23 дугаар байр	2022
	24 дугаар байр	2023
	22 дугаар байр	2024
Олимпын Хороо	“Бөртэ Чоно” шилдэг ивээн тэтгэгч	2023
Голомт	Топ 10 картаар үйлчлүүлэгч байгууллага	2016
Mongolian property awards	Шилдэг худалдааны төв	2016
Bloomberg	Bloomberg awards	2022

	ШАГНАЛ	ХУГАЦАА
Management forum	Шилдэг CEO	2022
Анунгоо /20 жилийн ой/	Топ харилцагч	2019
Худалдааны салбарын шагнал	“Мөнгөн богц”	2018
Талархалын батламж	Нийслэлийн засаг дарга, Улаанбаатар хотын захирагч Сумъяабазар	2022
Худалдааны салбарын шагнал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй дэд бүтэц, орчныг бүрдүүлсэн байгууллага	2017
ХҮДС-ийн Талархалын батламж	Хүүхэд гэр бүлд ээлтэй ААНБ	2021
	Манлай хүний нөөцийн төсөл	2019
	Нийслэлийн оны шилдэг шимтгэл төлөгч ажил олгогч байгууллага	2017
	Уншлагын танхим иж бүрэн тохижуулж өгсөнд талархал	2019
Хүндэт харилцагч	Монгол Чанар	2017
	Оны шилдэг харилцагч	2017
	Оны хамгийн өндөр борлуулалтын өсөлттэй харилцагч	2018
	Оны шилдэг харилцагч	2018
	Шилдэг барилга байгууламж шалгаруулалт	2016
	Шилдэг худалдааны төв	2016

ГИШҮҮН БОЛОН “САНАМЖ БИЧИГ” БАЙГУУЛСАН БАЙГУУЛЛАГУУД

БАЙГУУЛЛАГЫН НЭР

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим

Монголын Үндэсний Олимпын Хороо

Нийгмийн төлөө Хамтрагч байгууллагууд

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

Нийслэлийн Онцгой байдлын газар

Монголын Таеквондогийн Холбоо

Монгол Улсын Их Сургууль

Худалдаа Үйлдвэрлэлийн Их Сургууль

Голомт банк ХК

Худалдаа хөгжлийн банк ХК

“Бид Чадна” ТББ - хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний портал

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний төв

Тогтвортой Санхүүжилтийн Холбоо



emart

Монгол хүн Шд 100 наслав...